

ХҮНСНИЙ ХҮНГЭРСГЭЛ

№02
2022 ОН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Ухнаагийн ХҮРЭЛСҮХ:

**ХӨРС,
ХҮНС,
ХҮНГУРАВ
ХҮЙН
ХОЛБООТОЙ**



WWW.HUNSNIIHUVISGAL.MN



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



БАЯЛАГ БҮТЭЭГЧИЙН
ДЭМЖИХ ХӨЛӨӨ

ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

Хөрс эрүүл бол хүнс эрүүл – Хүнс эрүүл бол хүн эрүүл



12 "ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" ОРОН ДАЯАР...

Х.БОЛОРЧУЛУУН: Импортын гаалийн татварыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ хамгаална	6	Малыг эрүүл байлгахын тулд дархлаажуулах нь чухал	48
Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын албан тушаалтан, төлөөлөгчтэй уулзах үеэр хөндөж, ярьсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлууд	8	Уур амьсгалын өөрчлөлт ба бидний амьдрал	50
"Хүнсний хувьсгал" орон даяар... Зүүн гурван аймгаас... Төв, баруун, говийн бүсийн арван аймгаас... Өмнөговь, Дундговь, Төв аймгаас... Хангайн болон баруун бүсийн таван аймгаас... Улсын нийслэл Улаанбаатараас...	12	Цахим хөдөө аж ахуй	54
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН УУЛЗАЛТ	18	Уур амьсгалд ухаалаг хөдөө аж ахуй	56
УИХ-ын 36-р тогтоол	21	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЭХ ОРНЫ ӨНЦӨГ БУЛАН БҮРЭЭС... "Хүнсний хангамж, аюулгүй байдал – Газар тариалан" үндэсний чуулган "Хүнсний хангамж, аюулгүй байдал – Хүнс үйлдвэрлэл" үндэсний зөвлөгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал – Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инновац" үндэсний зөвлөгөөн "Хүнсний хангамж, аюулгүй байдал – Мал аж ахуй" үндэсний чуулган	60
Винод Ахужа: Монголчуудад дэлхийн хүнсний хангамжид хувь нэмрээ оруулах асар их нөөц, боломж бий	26	Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түнш бүлгийн хуралдаан боллоо	64
ХОРТ ХАВДАР БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХООЛ ХҮНС	32	"Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах тухай" Засгийн газрын тогтоол батлагдлаа	68
Хүнсний аюулгүй байдлын мэдээллийн товчоон	34	Орон нутгийн баялаг бүтээгчид "Хүнсний хувьсгал"-д нэгдлээ.	69
Монгол Улсад анх удаа "Хүнсний хувьсгал" дор...	36	Фото хураангуй ...	70
Олон улсын байгууллагуудын уулзалт	41		

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИЛГЭЭЛТ

“
Монгол хүний эрүүл,
аюулгүй амьдрах таатай
орчин, нөхцөлийг
бүрдүүлэх суурь
асуудлын нэг бол хүнсний
аюулгүй байдлыг хангах,
хүнсний хангамжийг
нэмэгдүүлэх юм”



“
Цаашид ч дэлхий нийтийн хүнсний
хангамж, нийлүүлэлтийн доголдол
хэдий хүртэл үргэлжлэх нь
тодорхойгүй байгаа бөгөөд энэ
нь манайх шиг хөгжиж буй улсын
хүнсний хангамж, аюулгүй байдал
хохирол учруулж болзошгүй”

Монгол Улсын Ерөнхийлөгч улс орны нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод” шилжих суурь реформын хүрээнд “100 жил-10 зорилт” хөгжлийн санаачилгыг дэвшүүлсэн. Энэ санаачилгын нэг чухал зорилт нь “Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа хүнс экспортлогч орон болох” явдал юм.

Дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдал, цар тахал, тээвэр ложистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэргээс шалтгаалсан хүнсний хангамж, аюулгүй байдал улс орон бүрийн нэн тулгамдсан сорилт боллоо. Тухайлбал, манай улсын хүнсний бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд 20 орчим хувиар огцом өсөж, инфляц 15 хувьд хүрч, ард иргэдийн амьжиргаа, улс орны эдийн засагт хүндээр тусаж байна. Цаашид ч дэлхий нийтийн хүнсний хангамж, нийлүүлэлтийн доголдол хэдий хүртэл үргэлжлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ нь манайх шиг хөгжиж буй улсын хүнсний хангамж, аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй. Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хангамж, аюулгүй байдал”

үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж байна. Монгол төрийн бодлогын цөмд монгол хүн, монгол өрх байж ирсэн, цаашид ч байх учиртай.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх суурь асуудлын нэг бол хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх явдал юм. Тиймээс хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж, иргэдийн эрүүл зөв амьдрал, хүний бие махбодын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нь онцгой чухал байна.



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг ирэх таван жилийн бодлого, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний хамт УИХ-д өргөн барьж батлуулсан. “Хүнсний хувьсгал”-ын үр дүнд ирэх таван жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж, цаашлаад хүнс экспортлогч орон болох эхлэл тавигдах учиртай. Энэ таван жилийн төлөвлөгөөг хийж хэрэгжүүлэхэд 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар тогтоолын төсөлд тусгасан. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь “Тэрбум мод” болон “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөнтэй нягт уялдаа холбоотой хэрэгжих ёстой.

“Хүнсний хангамж,
аюулгүй байдал” үндэсний
хөдөлгөөн нь “Тэрбум мод”
болон “Эрүүл монгол хүн”
үндэсний хөдөлгөөнтэй
нягт уялдаа холбоотой
хэрэгжих ёстой”

Бид хүнсээ өөрсдөө бэлтгэдэг, үйлдвэрлэдэг орон болохоос гадна дэлхийн хүн төрөлхтний хүнсний хангамжид өөрийн хувь нэмрээ оруулах ёстой. Үүнд баялаг бүтээгч тариаланчид, ногоочид, жимсчид, малчид, хүнсчид, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд болон нийт ард иргэд Та бүхний хичээл зүтгэл, хүчин чармайлт онцгой чухал ач холбогдолтой. Харин төр, засаг нь ард иргэд, баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжиж, бодлого нь тодорхой, дэмжлэг нь оновчтой, санхүүжилт нь хүртээмжтэй байж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дээд зэргээр сайжруулж, сэтгэл гарган хамтран ажиллах ёстой. Ингэснээр бид улс орон, ард түмнээрээ амжилтад хүрнэ.

Улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хүн бүр “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ, эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг эх оронч хэрэглэгч байхыг Төрийн тэргүүн ард түмэндээ уриалж байна.

**Эх орондоо “ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ” хийцгээе.
Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс
мандан бадрах болтугай.**

Бид хүнсээ өөрсдөө
бэлтгэдэг, үйлдвэрлэдэг
орон болохоос гадна
дэлхийн хүн төрөлхтний
хүнсний хангамжид өөрийн
хувь нэмрээ оруулах ёстой”





Х.Болорчулуун:

Импортын гаалийн татварыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ хамгаална

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хувьсгал”-ыг гол хэрэгжүүлэгч нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам билээ. Орон даяар өрнөж буй хөдөлгөөний ач холбогдол, хэрэгжүүлэх арга зам, хууль эрхзүйн орчин, хяналтын талаар тус яамны сайд Х.Болорчулуунаас тодрууллаа.

- Танд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Төрийн тэргүүний санаачилсан “Хүнсний хувьсгал”-ыг гол хэрэгжүүлэгч нь танай яам. Үндэсний хэмжээний тус хөдөлгөөнийг хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?

За, баярлалаа. Дэлхийн улс орнууд хүнсний баталгаат байдлаа сайжруулахад онцгой анхаарал хандуулж байгаа энэ цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлого, зохицуулалтыг үндэсний хэмжээнд эрс сайжруулах санаачилга гаргаж, үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлээд байна. Энэ хүрээнд УИХ-аас 36 тоот тогтоолыг баталж, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар түр хороо байгуулагдаж, чиглэл тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа. УИХ-ын тогтоол батлагдсанаар хууль, эрхзүйн орчныг сайжруулах, урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчингүй эрүүл бүс бий болгох, ирэх таван жилд хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар бүс нутагт хүнс экспортлогч орон болох зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвөөс гарах холбогдох зардлын санхүүжилтийг 2023 оны төсвийн төсөлд тусган батлууллаа.

- Тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд удирдлага, зохион байгуулалтыг хэрхэн хангаж ажиллаж байна вэ?

Хүнсний хангамжийн төлөвлөгөөнд удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хэд, хэдэн асуудал тусгасан. Нэгдүгээрт, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлнэ. Хоёрдугаарт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэхээр ажиллаж байна. Гуравдугаарт, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн их, дээд сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын чанарыг сайжруулахад нэлээд анхаарч байгаа. Мөн сая дурдсан салбаруудад тэргүүлэх чиглэлээр суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх зэргийг зохион байгуулан хэрэгжүүлж байна.

- Нийслэл болон орон нутагт “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд ямар бодлого, чиглэл баримтлах вэ?

УИХ, Засгийн газраас “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөр, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг баталж, салбарын тогтвортой хөгжлийг шинэ үе шатанд гаргах, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, малчид, тариаланчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, экспортлогч улс болох томоохон зорилт, үйл ажиллагааг дэвшүүлсэн. Энэ дагуу орон нутгийн удирдлагуудтайгаа хамтран, үүрэг, чиглэл өгч ажиллана. Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тухайн орон нутгийн хүн амын хүнсний аюулгүй байдал, хангамжийн асуудлыг орон нутгийн удирдлага зохион байгуулан шийдвэрлэхээр заасан байдаг. Хүн амын эрүүл мэндийн гол асуудал яригдаж байгаа учраас орон нутгийн удирдлага, холбогдох байгууллага, газар, хэлтсүүд хууль, дүрэм, журмаа сайтар хэрэгжүүлж ажиллана гэж итгэж байгаа. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний орон нутаг дахь хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор 21 аймагт хөдөлгөөн нээлтээ хийлээ. Олон нийт их ам сайтай, дэмжиж ажиллахаа илэрхийлж, бас санал, шүүмжлэл ч багагүй хэлж байсан. Үүнийг бид цаашдын ажилдаа тусгана.

- Манай улсын хүнсний хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдал өнөөдөр ямар түвшинд байгаа бол...

Манай улсын гол нэрийн нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс малын мах, улаан буудай, гурил, төмсийг дотооддоо 100 хувь хангаж байна. Харин сүүн бүтээгдэхүүн 27.1 хувь, гурилан бүтээгдэхүүн 38.2 хувь, хүнсний ногоо 38.5 хувь, өндөг 48.6 хувь, цөцгийн тос 67.4 хувь, тахианы мах 98 хувь, ургамлын тос 98.5 хувь нь импортын хамааралтай байна. Бас байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан тариалах боломж хязгаарлагдмал буурцагт ургамал, бүх төрлийн будаа, элсэн чихэр, загас, загасан бүтээгдэхүүн 100 хувь, хүнсний сав баглаа боодлын үндсэн түүхий эдийн 95 хувийг импортоор авдаг. 2021 онд 962 сая ам.доллар буюу 2.7 их наяд төгрөгийн хүнсийг бид импортоор оруулж ирсэн судалгаа гарсан. Тэгэхээр дотоодын хүнс үйлдвэрлэгчдээ бодлогоор дэмжиж, энэ салбарт хувьсгал хийх шаардлагатай байна. Ер нь хүнсний хангамж л доголдовол чанар бас доголддог. Өөрөөр хэлбэл хүнс сонголтгүй болоод ирэхээр хүмүүс олдсоноо хэрэглэж, эрүүл ахуй, чанар алдагдаад ирдэг. Тиймээс хүнсний аюулгүй байдал, чанар, хувьсгалын гол суурь нь хүнсний хангамжийг сайжруулах юм. Төрөөс импортын гаалийн татварыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ хамгаална.

- Иргэд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд ямар үүрэг, хариуцлагатай оролцох шаардлагатай байна вэ?

“ УИХ-ын тогтоол батлагдсанаар хууль, эрхзүйн орчныг сайжруулах, урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчингүй эрүүл бүс бий болгох, ирэх таван жилд хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар бүс нутагт хүнс экспортлогч орон болох зорилтыг тавиад байгаа”

Хүнсний тухай хуульд иргэд хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж, мэргэжлийн байгууллагад мэдээлэх, мөн хэрэглэгчийн хүнсний чанар, эрүүл ахуйг хангах үйл ажиллагаанд оролцох оролцоо зэргийг хуульчилсан байдаг. Тиймээс иргэд болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хүнсний аюулгүй байдалд тавих хяналтаа сайжруулж, хариуцсан байгууллагуудад нь мэдээлэл сайн өгч байх хэрэгтэй. Мөн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар боловсруулж буй хууль, журамд саналаа сайн хүргүүлэх хэрэгтэй. Нөгөө талаасаа иргэд, байгууллагууд дотоодын үйлдвэрлэлээ худалдан авалтаар дэмжих нь хамгаас чухал. Энэ нь эх орныхоо ирээдүйд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт, хувь нэмэр юм. Бас бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавих, мэдээлэх гол хүмүүс бол иргэд. Тиймээс худалдан авч буй бараа бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэсэн он, сар, өдөр, баталгаат хугацаа, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал, чанарыг сайтар харж, асуудал байвал үйлдвэрлэгч, хяналт тавьдаг байгууллагуудад нь хэлж, шаардлага хүргүүлэх хэрэгтэй. Ер нь иргэд маань өөрийн амь нас, бие махбодод хамгийн гол үүрэгтэй хоол хүнсэндээ онцгой анхаардаг байх хэрэгтэй.

- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдлын талаар ярина уу?

Үндэсний хөдөлгөөн өрнүүлсний үр дүнд хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс бүрэн хангах, ойрын болон дунд хугацаанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, цаашид экспортлох зорилгоор мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалангийн салбарын нөөц, боломжоос эхлээд хүнсний бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр, худалдаа, нийлүүлэлт, тээвэр логистик зэргийг цогцоор нь шийдвэрлэх юм. Тэгэхээр олон нийт ч гэсэн өөрийн болон үр хойчийнхоо эрүүл мэндийн төлөө Төрийн тэргүүний санаачилгыг дэмжиж ажиллана гэж итгэж байна.

Ярилцсан: С.Мөнхжаргал

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсын албан тушаалтан, төлөөлөгчтэй уулзах үеэр хөндөж, ярьсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлууд

НҮБ-ын Хүүхдийн сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн захирал Дебора Коминитэй уулзах үеэр (Улаанбаатар, 2022.05.12):

- Монгол Улс хүнс, хөдөө аж ахуйн экспортлогч улс болохыг зорьж байна. Хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр тэдний нийгэмд эзлэх байр суурь, эдийн засгийн чадамжийг сайжруулах боломжийг нээнэ. Манай улс хоёр хөршөөсөө эрчим хүчний хамааралтай учир бие даасан, эрчим хүч, эдийн засгийн хараат бус улс болохыг зорьж байна.



Бүгд Найрамдах Польш Улсын Гадаад хэргийн сайд Збигнев Раутай уулзах үеэр (2022.06.06):

- Хөдөө аж ахуй, тэр дундаа газар тариалангийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой, хүнсний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ногооны агуулах, зорь барих Польшийн туршлагаас суралцах, Монгол Улсыг органик хүнс үйлдвэрлэгч болж, бүс нутгийн хүнсний хэрэгцээг хангахад хамтран ажиллах сонирхолтой байна.



БНПУ-ын талаас өгсөн хариу:

- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн захирал Др. Такеши Касайтай уулзах үеэр: (Улаанбаатар, 2022.06.13):


- Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдалд анхаарал хандуулж байна. Энэ хүрээнд ирэх 5 жилд хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ хүнс экспортлогч улс болох зорилтыг тавиад байна.
- Эцэст нь үндэсний хөдөлгөөнүүдийн хүрээнд ДЭМБ үргэлжлүүлэн дэмжиж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ДЭМБ-ын талаас өгсөн хариу:

- Ирээдүйг харсан эдгээр олон санал, санаачилгуудыг бусад улс орнуудад жишээ болгож, Монгол Улстай үргэлжлүүлэн хамтран ажиллахад таатай байх болно.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутеррештэй уулзах үеэр (Улаанбаатар, 2022.08.09):

- Манай улс дэлхийн хүнсний хангамж, НҮБ-ын хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хүмүүнлэгийн тусламжийн төв, агуулахыг нисэх буудлаа түшиглэн байгуулах хүсэлтэй байгаа.



- Монгол Улсын хүнсний аюулгүй байдалд олон жилийн ган гачиг нөлөөлж, нийт газар нутгийн 77 орчим хувь нь цөлжилтөд нэрвэгдсэн. Малчид бэлчээргүй болж байна. Манай бэлчээрийн 90 хувь нь цөлжилтөд өртөх эрсдэлтэй гэсэн тооцоо гарсан. "Хөрс, хүнс, хүн" гурав бол харилцан шүтэлцээтэй зүйлс гэж боддог.

НҮБ-ын талаас өгсөн хариу:

- ОХУ, Украины хямрал хамгийн их санаа зовоож байна. Хүнс болон бордооны хомсдол, улс төрийн хоригдлын асуудлыг цаг алдахгүй шийдвэрлэх шаардлагатай байна. Хүмүүнлэгийн тусламжийн төв, агуулах байгуулах асуудлаар НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах алба (UNOCHA), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-тай зөвлөлдөн судалж үзье. Боломжтой болов уу гэж бодож байна. Суурин зохицуулагчийн газраас уг асуудалд анхаарч ажиллана уу.



БНСУ-ын Гадаад хэргийн сайд Пак Жинтэй уулзах үеэр (Улаанбаатар, 2022.08.29):

- Улс орон даяар "Хүнсний хувьсгал"-ыг эхлүүлээд байна. Энэхүү хүнсний хувьсгалын үр дүнд ирэх 5 жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж, цаашлаад Монгол Улс хүнс экспортлогч орон болох эхлэл тавигдах учиртай. Энэхүү томоохон зорилтыг хэрэгжүүлэх чиглэлд солонгосын талтай хамтран ажиллах сонирхолтой байна.

БНСУ-ын талаас өгсөн хариу:

- Монгол Улстай хамтран хийж бүтээх олон ажлууд байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн "Тэрбум мод", "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Эрүүл монгол хүн" санаачилгын хүрээнд хамтран ажиллах боломжтой. Манай улс дээрх салбарын хөгжлөөр дэлхийд тэргүүлж байна. Ялангуяа хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд хөдөө аж ахуйн чиглэлээр үр сортыг сайжруулах, дэвшилтэт технологи ашиглаж буй "Смарт фарм"-ыг нэвтрүүлж, харилцан ашигтай, бодит хамтын ажиллагааг өргөжүүлэхийг хүсч байна. Хоёр улсын хөдөө аж ахуйн хамтын ажиллагаагаар дамжуулан хүнсний аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх бололцоотой.



Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Рэжэп Тайип Эрдоантай уулзах үеэр (Самарканд, 2022.09.16):

- Монгол, Туркийн харилцаа, хамтын ажиллагааг хөдөө аж ахуй, эрчим хүчний чиглэлээр хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Монгол, Туркийн найрамдал, нөхөрлөл, хоёр улсын ахан дүүгийн харилцаа, хамтын ажиллагааны бэлэг тэмдэг болсон томоохон төслийг хэрэгжүүлэх сонирхолтой буйгаа илэрхийлэе.

БНТУ-ын талаас өгсөн хариу:

- Хөдөө аж ахуй, мал аж ахуй, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна.



НҮБ-ын ЕА-н 77 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд хэлсэн үг (Нью-Йорк, 2022.09.21):

- Монголчууд бид бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин удамтай ард түмэн билээ. Бидэн шиг нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг, байгаль дэлхийтэйгээ шүтэлцэн амьдардаг дэлхийн улс орны 200 гаруй сая хүний аж амьдрал уур амьсгалын өөрчлөлт, хөрсний доройтол, цөлжилт, ган зудаас шалтгаалан эрсдэлд ороод байна.
- Тэдний эрх ашгийг хамгаалах, бэлчээрийн менежмент, ашиглалтыг сайжруулах, экосистемийн тэнцвэрийг хадгалах, дэлхийн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үүднээс Монгол Улс 2026 оныг "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил болгох тухай" НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг санаачилж, 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлуулаад байна.
- Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, эрүүл орчинд эрүүл хүнс хэрэглэж эрүүл амьдрах орчин бүрдүүлэх зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний зэрэгцээ "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд энэхүү ажил, арга хэмжээнүүдэд олон улсын байгууллагууд бүс нутгийн улс орнууд хамтран ажиллаж байгаад талархаж байна.



Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтын нэгдсэн хуралдаанд хэлсэн үг (Шарм Эль-Шейх, 2022.11.08):

- Хөрс, хүнс, хүн гурав хүйн холбоотой. Хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл байна. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх үйл хэрэг бол хөрсөө хамгаалах, хүнсээ хамгаалах, хүнээ хамгаалах хүн төрөлхтний суурь асуудал мөн. НҮБ-ын 2021 оны судалгаагаар дэлхийн хүн амын 30 орчим хувь буюу 2.3 тэрбум хүн хүнсний аюулгүй байдлын эрсдэлд ороод байгаа бөгөөд 828 сая хүн өлсгөлөнд нэрвэгдээд байгаа тухай тайлан гарсан. Ийм учраас улс орон бүр хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд цогцоор нь авч үзэх нь зүйтэй юм.
- Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах үүднээс "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Эрүүл монгол хүн", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнүүдийг эх орондоо санаачлан зохион байгуулж байна.



БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй албан ёсны хэлэлцээ хийх үеэр (Бээжин, 2022.11.28):

- Монгол Улсаас Хятад улс руу гаргах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бид анхаарч ажиллах ёстой.

БНХАУ-ын талаас өгсөн хариу:

- Хөдөө аж ахуйн сайн чанарын барааны асуудал. Мах махан бүтээгдэхүүний экспорт өмнө нь малын халдварт өвчнөөс болоод тасалддаг байсан байх. Үүнийг сайтар шийдэх ёстой.




БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцянтай уулзах үеэр (Бээжин, 2022.11.28):

- Монгол Улсаас Хятад улс руу гаргах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл ахуй, чанар, стандарт, хорио цээрийн нөхцөлийг харилцан тохиролцох зэрэг чиглэлээр идэвхтэй хамтран ажиллах саналтай байна.

БНХАУ-ын талаас өгсөн хариу:

- Хоёр талын худалдааны эргэлтийг 20 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг биелүүлэхэд хятадын тал монголын талтай идэвхтэй зохицуулалт хийж, хоёр талын худалдааны түвшинг дахин нэг шат ахиулахад бэлэн байна.



Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэлд (Бээжин, 2022.11.28):

- "Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр" болон "Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөр"-ийг идэвхтэй хэрэгжүүлэх, ойрын хугацаанд хоёр талын худалдааны нийт хэмжээг 20 тэрбум ам.долларт хүргэх, хоёр улсын аж ахуйн нэгжүүд зах зээлийн зарчмын дагуу нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх, нүүрсний дунд, урт хугацааны худалдааны гэрээ байгуулахыг дэмжих"



Япон Улсын Ерөнхий сайд Кишида Фүмиотой уулзах үеэр (Токио, 2022.11.29):

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Япон Улстай хамтран ажиллах сонирхолтой байна. Бид хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ хүнс экспортлогч орон болох зорилт тавин ажиллаж байна.



"Монгол Улс, Япон Улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл"-ийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан мэдэгдэлд (Токио, 2022.11.29):

- "Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, түүний дотор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өсгөн нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал, Япон Улсаас хөрөнгө оруулалт татах зорилгоор хууль эрх зүйн болон бизнесийн орчинг сайжруулах, эрдэс баялаг, нэн ялангуяа газрын ховор элементийн хайгуул, олборлолтын салбарт хамтран ажиллах боломжийг судлах, эрчим хүчний салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох чиглэлээр хамтран ажиллана" гэж заасан.





"ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" ОРОН ДАЯАР...

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт албан ёсоор эхлүүлж, эрчимжүүлэх зорилготой "Хүнсний хувьсгал" зөвлөгөөнийг 21 аймагт зохион байгуулахаар дөрвөн Ажлын хэсэг дөрвөн зүгт хүлгийн жолоо залсан билээ. ХХААХҮЯ-ийн сайд Х.Болорчулуунаар ахлуулсан албаныхан зүүн гурван аймагт, Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяраар ахлуулсан Ажлын хэсэг төв, баруун, говийн бүсийн 10 аймагт, Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх О.Буяннэмэхээр ахлуулсан Ажлын хэсэг Төв, Өмнөговь, Дундговь аймагт ажиллав. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнгээр ахлуулсан баг хангайн болон баруун бүсийн таван аймагт тус, тус ажиллаж, "Хүнсний хувьсгал"-ын салхийг орон нутагт сэвэлзүүллээ.

“**Эх орныхоо дөрвөн зүг, найман зовхист хүрч, 21 аймгийн арг иргэддээ Төрийн тэргүүний санал, санаачилгыг танилцуулан түгээж, “Хүнсний хувьсгал”-ын эхлэлийг тавьсан дөрвөн Ажлын хэсгийн “аяны богц” болон хүн амын гуравны нэг нь аж төрдөг нийслэл Улаанбаатар хотын “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийг эрхэм уншигчдагаа товчлон хүргэе**”



Зүүн гурван аймгаас...

Улсын зүүн хязгаар, наран ургах зүгт орших Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймагт ХХААХҮ-ийн сайд Х.Болорчулуунаар ахлуулсан, тус яамны дэд сайд М.Ганхүлэг, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун тэргүүтэй албаныхан ажилласан.

Ажлын хэсгийн эхний дөрөө мулталсан Эзэн Чингис хааны өлгий нутаг, Монгол Улсын ууган дөрвөн аймгийн нэг Хэнтий аймаг мянгат, аварга малчдынхаа тоогоор олон жил улсад тэргүүлж буй мал аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон нутаг. Энэ онцлогоо цаашид хадгалж, малынхаа эрүүл мэнд, малын гаралтай бүтээгдэхүүнийхээ чанарт анхаарч, аймаг болон улсын махны хэрэгцээг хангахад тодорхой хувь нэмрээ оруулахаа малчид, аж ахуйн нэгжүүд илэрхийллээ. Мөн нутгийн нэрийн хуудас болсон талх, нарийн боов үйлдвэрлэгчид ч өөрсдийн хэмжээнд хүнсний хангамжид гар бие оролцохоо салбарын сайдад уламжилсан юм.



Сүхбаатар аймаг махны, Дорнод аймаг мах, гурилын хэрэгцээгээ 100 хувь өөрсдөө хангадаг. Ирэх дөрвөн жилд тус хоёр аймаг сүү, төмс, цагаан идээнийхээ үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлээсээ 100 хувь хангах зорилго тавьсан төдийгүй, бусад аймаг, нийслэлийн хэрэглэгчдэд нийлүүлэхээр төлөвлөж байгаа аж.

Зүүн гурван аймаг мал аж ахуй, тэр дундаа эрчимжсэн мал ахуй хурдацтай хөгжиж буй бүс нутаг. Улсын хэмжээнд байгуулах гурван эрүүл бүсийн нэгийг тус бүс нутагт байгуулах бөгөөд Дорнод аймгийн Халхгол суманд 100 мянган үхэр бордох аж ахуй байгуулж эх орныхоо хүнсний хангамжид хувь нэмрээ оруулахаа илэрхийлэв. Мөн махны чиглэлийн цөөнгүй компани ОХУ, Казахстан, Киргизстан, Узбекистан, Иран улс руу мах экспортолдог юм байна. Тэд мөн чанар, стандартдаа анхаарч, хэмжээг нь нэмэгдүүлэхийг зорьж байгаа аж. Энэ нь малчдын амьжиргаа болон эх орны эдийн засаг, цаашлаад дээрх улсуудын хүнсний хангамжид оруулж буй томоохон хувь нэмэр гэдгээ ч онцлон хэлж байлаа.



Төв, баруун, говийн бүсийн 10 аймгаас...



Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяраар ахлуулсан Ажлын хэсэг орон нутагт хүнсний хувьсгалын хөдөлгөөнийг эхлүүлэх томоохон ажлын дийлэнхийг нугалсан гэж болно. Хоймор нутгаас зөвлөгөөнөө эхлүүлсэн багийн хамт олон Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь зэрэг 10 аймгийн иргэд, малчид, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзаж, санал бодлыг нь сонсон "Хүнсний хувьсгал"-ын хөдөлгөөний нээлтийг хийсэн билээ.

Аялал жуулчлал, загас ан агнуур, цайны ургамлаараа алдартай Хөвсгөлчүүд хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг илүү эрчимжүүлж, хүнс үйлдвэрлэгчид, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарахаа илэрхийлсэн. Газар тариалангийн үйлдвэрлэлээр улсад эхний гуравт багтдаг анхдагчдын өлгий нутаг Булганчууд хүн амыг стратегийн хүнсээр хангахад хувь нэмэр оруулж ирсэн амжилтаа улам ахиулж, мөн хөдөө аж ахуйн салбараа ч хөгжүүлж "Хүнсний хувьсгал"-д нэгдэхээ уламжилсан юм.

Орхон аймгийн хувьд хүнсний брэнд бүтээгдэхүүн хомсдолтой байдаг бөгөөд нийт

хэрэглээнийхээ дийлэнх, тухайлбал нарийн боов, талхныхаа 70 орчим хувийг бусад орон нутгаас авдаг учраас одоо байгаа үйлдвэрүүдээ дэмжиж, аймгийнхаа хэрэгцээг бүрэн хангах зорилт дэвшүүлж, "Хүнсний хувьсгал"-д нэгдлээ. Тэгвэл Сэлэнгэчүүд "Хүнсний хувьсгал"-ыг ирэх таван жилд манлайлах аж. Тодруулбал улсын үр тарианы 40 орчим хувийг үйлдвэрлэж, хүнсний ногооны 50 хувийг дангаараа хангаж, аймгаасаа мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооныхоо хэрэгцээг 100 хувь хангадаг шимт хөрсний эх орон болсон тус нутгийн түмэн үнэхээр ч "Хүнсний хувьсгал"-ыг манлайлахаас яах билээ дээ. Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг ч тус аймаг тэргүүлж оролцож буй.

Хүнс үйлдвэрлэгч гол аймгуудын нэг Дархан-Уулынхан "Хүнсний хувьсгал"-д дөрвөн чиглэлийн 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бол Баруун бүсийн тулгуур төв Ховд аймаг үндэсний хөдөлгөөнийг үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалтдаа суурилан аж үйлдвэрийн сэргэлттэй хоршиж хэрэгжүүлэх аж. Мөн ийн хэрэгжүүлэхдээ брэнд бүтээгдэхүүн бий болгохыг зорино гэдгээ нутгийн удирдлагууд онцолж байлаа.



Баруун хязгаарын жимс, жимсгэнэ, халтар арвай, эрдэнэ шишээрээ алдартай Говь-Алтайчууд нутгийнхаа онцлогтоо тулгуурлан орон нутагтаа "Хүнсний хувьсгал" хийхийн сацуу улсын хэмжээнд сонгино, саримсны хэрэгцээг 100 хувь хангахаар зорьжээ. Гэхдээ орон нутагт үйлдвэрлэл эрхлэхэд түүхий эдийн хангамж дутагддаг учир үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ асуудал шийдэгдэх болов уу гэсэн хүлээлтэй байгаа аж.

Тэмээн сүргийнхээ тоо толгойгоор улсад олон жил айрагдсан Хонгор нутгийнхан ингэний

идээ цагаа, ямааны тослог бор ааруул, сарлагийн ерөм зэрэг цагаан идээгээрээ алдартай. Энэ онцлогтоо тулгуурлан шинэ суурьшлын бүсдээ хуурай ингэний сүүний үйлдвэр барьж ажлын байр бий болгосон төдийгүй ирэх таван жилд мөн л энэ төрлөөрөө гол үүрэгтэй оролцохын зэрэгцээ дэлхийн зах зээлд гарах хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарна гэдгээ Баянхонгор аймгийн удирдлагууд онцолж байлаа. Мөн үйлдвэр технологийн парктаа суурилан "Хүнсний хувьсгал"-д идэвхтэй оролцох юм. Тэгвэл жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээрээ алдартай Говьсүмбэр аймгийнхан мөөгний кластерийг бий болгож, хүнсний үйлдвэр нэмж байгуулахаар зорьж байгаа аж. Харин эх орны зүүн өмнөд бүсийн хилийн манаа Дорноговьчууд хүнсний салбараа кластер хэлбэрээр хөгжүүлж, брэнд бүтээгдэхүүнүүдээ экспортлох зорилт тавьжээ. Түүнчлэн тэмээн сүргийнхээ ашиг шимээр үйлдвэрлэсэн онцлог бүтээгдэхүүн гарган авах, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өндөг болон бусад хүнсний аж ахуй хийгээд хамгаалагдсан хөрс буюу хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаа юм байна.



Өмнөговь, Дунговь, Төв аймгаас...



Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх О.Буяннэмэхээр ахлуулсан Ажлын хэсэг Төв, Өмнөговь, Дундговь аймагт ажиллаж, "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг албан ёсоор нээн "Хүнсний хувьсгал" зөвлөгөөн зохион байгуулаад ирсэн. Төв аймгийн удирдлагууд хүнс экспортлогч улс болох зорилтыг хангахад түшиц аймаг болох, мөн нийлүүлэгч аймгаас үйлдвэрлэгч аймаг болох зорилт тавин ажиллаж буйгаа хэлж байлаа.

Эх орны үүдэн хилийг манан оршдог Өмнөговь аймгийнхан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр 15 зорилт, 27 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тухайлбал, тэмээн сүргийн тоо толгойгоороо олон жил улсад тэргүүлж, ингэний сүү, хоормогоороо алдартай тус аймгийнхан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, малчид болон эрчимжсэн аж ахуйг урамшуулалд хамрагдах боломжийг бүрдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангахад хөрөнгө оруулалт татах аж. Харин дуу хуурын өлгий нутаг Дундговьчуудын хувьд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хангамжийн хувийг өсгөх, стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, аюулгүй мах, махан бүтээгдэхүүн, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүнээр хүн амынхаа хэрэгцээг хангахыг зорьж байгаа юм. Мөн хамгаалагдсан хөрсний тариалалтыг эрчимжүүлэн ургацын хэмжээг нэмэгдүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хүнсний ногооны хэрэгцээг хангахаас гадна эрүүл, чанартай, ашиг шим өндөртэй мал өсгөн үржүүлж, хүн амыг эрүүл хүнсээр хангахаар төлөвлөж байна.

Хангайн болон баруун бүсийн таван аймгаас...

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнгээр ахлуулсан баг хангайн болон баруун бүсийн Өвөрхангай, Увс, Завхан, Баян-Өлгий, Архангай аймагт ажиллаж "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг албан ёсоор нээсэн. Зөвлөгөөний салхийг хагалсан Өвөрхангай аймгийнхан үр тариа, төмсний хэрэгцээгээ 100 хувь аймгаасаа хангах, малын эрчимжсэн болон туслах аж ахуй байгуулах, 10 суманд мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори бий болгох зэрэг 40 ажлыг 2027 он хүртэл хийхээр төлөвлөжээ. Тэгвэл цагаан идээгээрээ алдартай Архангайчуудад Т.Жамбалцэрэн дарга давсны олборлолтоо нэмэгдүүлж, сүүний үйлдвэрлэлээ хөгжүүлэх, мөн газар тариалангийн салбартаа илүү анхаарахыг санал болгосон мөн тус аймгийн ХХААГ-ын дарга хуванцар савны хэрэглээг халж, цаашид хэрэглэхгүй байхыг зөвлөгөөнд оролцогсдод уриаллаа.



Малын эрүүл мэндийн чиглэлээр жишиг болохуйц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж буй Завхан аймаг нийт 33 зорилт бүхий 20 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан "Хүнсний хувьсгал"-д нэгджээ. Тус аймаг сүүний үйлдвэргүйгээс сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээгээ хангаж чаддаггүй. Харин үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжилт олгосноор сүүний үйлдвэр байгуулах боломжтой болж байна. Мөн цаашид хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангадаг болох зорилт тавьж, энэ хүрээнд 1,000 тонны багтаамжтай хүнсний ногооны зоорь барихаар төлөвлөжээ.

Баруун хязгаарын Баян-Өлгий аймагт болсон "Хүнсний хувьсгал" зөвлөгөөнд 13 сумын 200 гаруй хүн оролцож, 25 аж ахуйн нэгж үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Өлгийчүүд удирдлага, зохион байгуулалт, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл чиглэлийн нийт 34 ажлыг хийж хэрэгжүүлэн "Хүнсний хувьсгал"-д нэгдэж байгаа бол чацарганаараа алдартай Увс аймгийнхан "УВС брэнд"-ийн дор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон бизнес эрхлэгчдээ нэг кластерт нэгтгэжээ. Ийн бүтээгдэхүүнээ чанарын өндөр түвшинд бэлтгэж, экспортод гаргах зорилт тавин ажиллаж байна.

Улсын нийслэл Улаанбаатараас...

"Хүнсний хувьсгал" хөдөлгөөнийг ийнхүү 21 аймагт нээж, албан ёсоор эхлүүлсний дараа улсын хүн амын гуравны нэг нь аж төрдөг улсын нийслэл Улаанбаатар хотод 2022 оны 11-р сарын 15-ны өдөр зөвлөгөөнөө зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн мэндчилгээг Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх Ч.Даваабаяр уншиж танилцуулан, Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазарт гардуулснаар нээсэн тус арга хэмжээнд ХХААХҮЯ-ны удирдлагууд, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэн, судлаачид, баялаг бүтээгч, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, газар тариалан, мал аж ахуйн салбарын 1200 гаруй зочид, төлөөлөгч оролцлоо. Нийслэлийн хувьд өндөг, сүү, хүлэмжийн аж ахуйн хэрэгцээгээ 100 хувь хангаж, цаашид агуулах, тээвэр ложистикийн асуудлаа шийдвэрлэх томоохон төлөвлөлтийг танилцууллаа. Мөн иргэдийнхээ хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд орон нутгуудтай хамтарч ажиллах аж.

Ийнхүү "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн 21 аймаг, нийслэлд нээлтээ хийж дууссанаар, 19 гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашлаад экспортлогч орон болохын төлөө зорьж буй "Хүнсний хувьсгал" улам эрчимжлээ. Тогтоол шийдвэрийг батлах, батлалцах, мөн түүчээлэх өндөр үүрэг хариуцлага төрийн түшээд, албаныханд бий. Тэрхүү үүргээ ч Төрийн тэргүүний санаачилгаар эхлүүлэн парламент нь баталж, Засгийн газар нь дэмжин төлөвлөж, анх удаа 29 байгууллагыг нэгтгэх, түүхэндээ төрийн хүчийг тэр чигт нь хөдөлгөж, "Хүнсний хувьсгал"-ын шанг татлаа. УИХ-ын 36 дугаар тогтоолыг ажил хэрэг болгоход арилжааны банкуудын бага хүүтэй, урт хугацаатай зээлийн дэмжлэг маш чухал. Дэлхий нийтээрээ хүнсний хомсдолд орж буй энэ онцгой цаг үед эх оронч шийдвэр гаргаж, ард иргэдийнхээ хүнсний хангамж, улсынхаа ирээдүйд томоохон хөрөнгө оруулалт хийж, хувь нэмрээ оруулах амин чухал хэрэгцээ байгааг банкны удирдлагууд мэдэрч байгаа гэдэгт итгэлтэй байна. Мэдээж "Хүнсний хувьсгал"-д хүн нэг бүрийн оролцоо чухал. Өөрсдийн болон ирээдүй хойч үеийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдал, эх орынхоо эдийн засаг, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах эсэх нь та биднээс шалтгаална. Дотооддоо "Хүнсний хувьсгал" хийж, цаашлаад дэлхийд ч гарах боломж таны гарт байна.

Бэлтгэсэн: С.Мөнхжаргал, Г.Лхагвадулам, А.Адьяажав

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН УУЛЗАЛТ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнсний салбарынхан, үндэсний үйлдвэрлэгчид, малчид, тариаланчид, баялаг бүтээгчидтэй угаа дараа уулзаж, санал, хүсэлтийг нь сонсож буй.



Төрийн тэргүүн эхний ээлжид Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн тариалангийн бүс нутагт ажиллан, ургац хураалтын явцтай танилцаж, газар тариалан эрхлэгчидтэй уулзаж, санал, бодлыг нь сонссон юм. Тариаланчид хүнсний хэрэгцээгээ дотоодоосоо бүрэн хангаж, экспортлох боломжтой бөгөөд ургуулж, үржүүлсэн эко хүнс, ногоогоо хадгалах зоорь, агуулах, хүлэмж, урт хугацаатай, хүү багатай зээлийн эх үүсвэрүүд зайлшгүй шаардлагатай байгааг онцлон хэлж байв. Мөн эрчимжсэн мал аж ахуйн фермүүдээр орж танилцах үеэр усалгааны систем, фермийн тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр авах,

эргэлтийн хөрөнгөтэй болох зэргээр кластераар нь дэмжих шаардлагатайг уламжилж байлаа. Түүнчлэн Ерөнхийлөгч мах, ногооны хөргүүртэй агуулах, хүлэмжийн аж ахуй болон шувууны аж ахуй эрхлэгчидтэй уулзаж, тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон юм.

Төрийн тэргүүний уулзалт



Хөдөө аж ахуйн салбар бол Монгол Улсын нийт ажиллах хүчний 60-аад хувийг эзэлдэг, Дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувийг бүрдүүлдэг, уул уурхайн дараа ордог том салбар билээ. Цар тахлын улмаас тус салбарын үнэ цэн улам нэмэгдэж буй. Тиймээс бусад улс орныг манлайлан эх орондоо “Хүнсний хувьсгал”-ыг өрнүүлж, эрүүл, аюулгүй хүнсээр дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй дэлхийн хүнсний хангамжид хувь нэмрээ оруулах ёстой юм.

“Ирэх оны төсөвт 138 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжүүдийнхээ үйл ажиллагааг дэмжихэд зарцуулахаас гадна хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирвэл 2027 он хүртэл Гаалийн албан татварыг тэглэж, тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлнэ”



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хүнсний салбарын үйлдвэрүүдэд мөн ажилласан. Тэрбээр олон хүнийг ажлын байраар хангаж, баялаг бүтээж яваа үндэсний томоохон аж ахуй нэгж болох “Гацуурт хүнс” ХХК, “М-Си-Эс Кока Кола” ХХК, “Үлэмж органик” ХХК, “Цалуут импекс” ХХК, “Баялаг фийд” ХХК-ийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр ирэх оны төсөвт 138 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжүүдийнхээ үйл ажиллагааг дэмжихэд зарцуулахаас гадна хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирвэл 2027 он хүртэл Гаалийн албан татварыг тэглэж, тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болсныг үйлдвэрлэл эрхлэгчдэд дуулгалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжсэн түүхэн шийдвэр бөгөөд зорилгыг хамтдаа биелүүлэхийн төлөө бүх хүчээ дайчлан ажиллахаа уулзалтад оролцогсад илэрхийлж байлаа.



Бэлтгэсэн: С.Мөнхжаргал, Б.Эрдэнэбилэг, А.Адъяажав



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Я.СОДБААТАР:

Өнөөдөр дэлхий дахинд үүсээд буй геополитикийн хурцадмал байдал, цар тахлаас шалтгаалсан тээвэр логистикийн хүндрэл, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэрэг нь дэлхий нийтийн хүнсний хангамж, аюулгүй байдалд томоохон сорилт, бэрхшээлийг дагуулж байна.

НҮБ-ын судалгаагаар 2021 оны байдлаар дэлхийн 53 орны 193 сая хүн хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орсон ба энэ тоо ганцхан жилийн дотор 40 сая хүнээр өссөн судалгааны дүн гарчээ. Нөхцөл байдал энэ онд ч сайжрахгүй төлөвтэй байгааг олон улсын байгууллагууд анхааруулж байна.

Монгол Улс мах, улаан буудай, төмсний дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг хэдий ч нийт хүнсний бүтээгдэхүүнийхээ 50 орчим хувийг импортоор авч байгаа нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал болон ард иргэдийн хүнсний хангамж, аюулгүй байдалд том эрсдэл байгааг харуулж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг санаачилсан бөгөөд УИХ-аас 36 дугаар тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. УИХ энэхүү тогтоолыг батлахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, салбарын удирдлага зохион байгуулалт, газар тариалан, мал аж ахуйн салбарын болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр ойрын жилүүдэд хийж хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн юм. Ингэснээр ирэх таван жилд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашлаад бүс нутагтаа хүнс экспортлох зорилтыг ханган хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын үндэс тавигдсан болно.

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд газар тариалан, хүнс үйлдвэрлэгчид, эрдэмтэн судлаачид, малчдыг оролцуулсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Газар тариалан", "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Хүнс үйлдвэрлэгчид", "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Шинжлэх ухаан, технологи, инновац", "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Мал аж ахуй үндэсний зөвлөгөөн"-ийг тус, тус 21 аймгийн оролцоог ханган зохион байгууллаа. Түүнчлэн төрийн 29 байгууллага нэгдэж, УИХ-ын байнгын хороодын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсныг олон улсын байгууллагууд дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлээд байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангахад хүнсний асуудал хариуцсан төрийн байгууллагуудаас гадна энэ салбарын хувийн хэвшлийнхэн, эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн судлаач нар болон нийт ард иргэдийн нягт хамтын ажиллагаа чухал юм.

Улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, үр хүүхдүүдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө хүн бүр "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авдаг эх оронч хэрэглэгч байхыг ард түмэндээ уриалж байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 36

Төрийн ордон, Улаанбаатар хот

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2."Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:

а/хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/энэ тогтоолын хавсралтад заасан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

в/тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

г/хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д/хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг шинэчилж, шинээр батлах;

е/мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх;

ж/хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг боловсруулан батлах;

з/хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах;

и/хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

к/хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын татаас, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт бүрэн тусгаж, хэрэгжүүлж байх.

2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

а/"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг урт хугацаатай, хүү багатай эх үүсвэрээс санхүүжүүлэх, улсын болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулах;

б/"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Засгийн газраас батлан улс орон даяар "Эх орны эрүүл хүнс" уриан доор хэрэгжүүлж байгаа "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-тай уялдуулан хэрэгжүүлэх;

в/хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

г/мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх;

д/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

е/хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрийн өмчит их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, сургалтын чанарыг сайжруулах, эдгээр салбарт тэргүүлэх чиглэлээр суралцагчид сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, мэргэшсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах;

ж/хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах;

з/монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс

бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

и/хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэхээр нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжид татварын болон бусад дэмжлэг үзүүлэх;

к/Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

л/хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хүрээлэнгээр захиалгат судалгаа, туршилтын ажил хийлгэх хөрөнгийг нэмэгдүүлэх.

3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 5000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах;

б/ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд тулгуурлан улсын хэмжээнд улаан буудайн 4, тэжээлийн 2, хүнсний ногооны 5, төмсний 4, нийт 15 үрийн аж ахуйг байгуулах, сорт сорилтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх;

в/"Монгол Улсад газар тариалан эрхлэх систем" технологийн баримт бичгийг мөрдлөг болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах, сайжруулах, зохистой ээлжлэн тариалалт бүхий дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнд нийцсэн техник, технологийн шинэчлэл хийх;

г/тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйд шаардагдах дотоодын хэрэгцээт тэжээлийн хангамжийг 1.9 сая тоннд хүргэхэд зохион байгуулалт болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

д/хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 270 гектар хүртэл нэмэгдүүлэн хөгжүүлж, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, дулааны хангамж, дэд бүтэц бүхий бүс нутгуудад 50 гектар өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;

е/хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр уул уурхайн үйлдвэрийг түшиглэн азот, фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

ж/бүх төрлийн будаа, чихрийн манжин, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, шаардлагатай санхүүжилт, зээл олголтын оновчтой тогтолцоог бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх;

з/стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорины багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх;

и/байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах зорилгоор экологид ээлтэй, усыг зөв зохистой ашиглах усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах, шинэчлэх, усан сан бүхий ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, дэмжлэг үзүүлэх;

к/үйлдвэр, фермер, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн кластерыг бий болгоход чиглэсэн хөдөө аж ахуйн агро парк байгуулах;

л/"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвд 30 гектар, сумын төвд 10 гектар агро ойн аж ахуйг тус тус байгуулах, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах;

м/жил бүрийн намрын ургацаас стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.0 мянгаас доошгүй тонн хүнсний улаан буудайг худалдан авах нөөц бүрдүүлэх.

4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулах, малчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хамтран ажиллах;

б/мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж,бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, шинэчлэх, хоршоолох хөдөлгөөнийг бүх талаар дэмжих;

в/хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах;

г/гахай, тахианы болон өсвөр хонь, үхэр бордох аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулахад аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, урт хугацаатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

д/зөгийн аж ахуйг хоршоолсон хэлбэрээр хөгжүүлэх, түүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх;

е/мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах.

5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;

б/хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

в/цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах;

г/хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихрийн боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

д/хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр /автомашин, вагон, онгоц/ тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх;

е/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

ж/хүнсний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний амт чанар, сав, баглаа боодлыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэн экспортын зориулалтын брэндийг хөгжүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих;

з/хүнсний нэмэлт, биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг дэмжих;

и/улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

к/хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.

3.Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР





Винод Ахужа:

Монголчуудад дэлхийн хүнсний хангамжид хувь нэмрээ оруулах асар их нөөц, боломж бий

©FAO



“

2019 онд дэлхийн хэмжээнд 15-49 насны гурван жирэмсэн эмэгтэй тутмын нэг нь цус багадалтаар өвчилсөн нь 2012 оноос хойш 1.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Насанд хүрэгчдийн таргалалт дэлхийн бүх бүс нутагт нэмэгдэж байна. Эрүүл хооллолтын үнийг илүү хямд болгохгүйгээр хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зорилтуудыг биелүүлэх боломжгүй”

©FAO

“Хүнсний хувьсгал” сэтгүүлийнхээ энэ удаагийн зочны хойморт НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч, ноён Винод Ахужаг урьж, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй яриа өрнүүлээ.

- Урилгыг маань хүлээн авч, цаг гарган ярилцаж байгаа Ноён Винод Ахужа танд баярлалаа. Өнөөдөр олон улсын хүнсний хангамж, аюулгүй байдал ямар түвшинд байгаа талаар ярилцлагаа эхлэх үү?

Тантай уулзаж ярилцах завшаан тохиосонд баяртай байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын эрхэм зорилго бол дэлхий дээрх өлсгөлөнг устгах, хүн эрүүл, идэвхтэй, амьдрах үндэс болох чанартай хүнсний тогтвортой хангамжийг бий болгох боломжийг бүрдүүлэх юм.

Манай байгууллага “Хэнийг ч орхигдуулахгүй” уриаг энэ жил тодотгож байгаа тул олон улсын хүнсний хангамж, аюулгүй байдлыг илтгэх цөөн хэдэн тоон мэдээллийг дурдмаар байна. Дэлхий нийт 2021 онд цар тахлаас ангижирч, хүнсний аюулгүй байдал сайжирна гэж найдаж байсан ч өлсгөлөнд нэрвэгдсэн хүний тоо улам бүр нэмэгдээд байна. 2021 онд 800 сая орчим хүн өлсгөлөнд нэрвэгдсэн байгаа нь корона вирусийн



“
Үнийн огцом өсөлт
нь дэлхийн бүх
бүс нутагт эрүүл
хооллолтын дундаж
өртөг ба хүртээмжид
шууд нөлөөлсөн”

Үнийн огцом өсөлт нь дэлхийн бүх бүс нутагт эрүүл хооллолтын дундаж өртөг ба хүртээмжид шууд нөлөөлсөн. Тэр дундаа Ази тивд хамгийн огцом өөрчлөлт гарсан нь 2022 оныг 2019 онтой харьцуулахад нэмж 78 сая хүн эрүүл хоол, хүнсний хэрэглээг төлж дийлэхгүйд хүрсэн байна. Иймд дэлхий дахинд тулгарч буй хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн асуудал, эдийн засаг, эрүүл мэнд, байгаль орчны сорилт бэрхшээлийг харгалзан хүнс, хөдөө аж ахуйн тогтолцоог өөрчлөн сайжруулах нь нэн чухал юм. НҮБ-ын ХХААБ нь үүнд шаардагдах арга ухаан, мэдлэг, дэлхийг хамарсан хүрээлэлтэй бөгөөд бид үндэсний хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж, шим тэжээлийн хэрэгцээг шийдвэрлэхийн зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хангахад ихээхэн хувь нэмэр оруулж чадна.

- Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хувьсгал” өрнүүлэх санаачилга гаргасан. Үүнийг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрхэн дэмжиж, хамтран ажиллаж байгаа вэ?

Манай байгууллагын хувьд Монгол Улсын Засгийн газар хүнсний аюулгүй байдлыг хангах, шим тэжээлийг сайжруулах, тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хүчин чармайлтаа эрчимжүүлж, энэхүү санаачилгыг улсын хамгийн дээд байгууллага удирдан чиглүүлж байгаад үнэхээр баяртай байна. Бид УИХ-ын тогтоол, ажлын хөтөлбөрийг нарийвчлан

судалж үзээд төлөвлөгөө нэлээд уялдаатай байна гэж харсан. Манай төсөл, хөтөлбөрүүд “Хүнсний хувьсгал”-тай маш сайн уялдаж байгаад баяртай байна. Бид одоогоор бодлого, дүн шинжилгээ, малын эрүүл мэнд ба Нэг эрүүл мэнд, цахимжилт, уур амьсгалын өөрчлөлт ба сэргэх чадвар, нэмүү өртгийн сүлжээ, хүлэмжийн хүнсний ногооны үйлдвэрлэл, олон нийтийн боловсрол, хүнсний хог хаягдлыг багасгах, биологийн олон янз байдал, газар, ус зэрэг чиглэлээр ажлаа эрчимжүүлж байна. Хамгийн гол нь залуучууд, эмэгтэйчүүдэд хүрч ажиллах болно. Бид салбарын яам агентлаг, Ерөнхийлөгчийн Тамгын газартай нягт хамтран, хүчин чармайлтаа сайтар уялдуулж, хамтдаа үр нөлөө үзүүлэх зорилготой.

- Бид хүнсээ өөрсдөө бэлтгэдэг, үйлдвэрлэдэг орон болохоос гадна дэлхийн хүнсний хангамжид хувь нэмрээ оруулах төлөвлөгөөтэй. Ийм боломж бүрдүүлэхэд манай улс хэр ойрхон байна вэ гэдэгт та байр сууриа илэрхийлэхгүй юу?

Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, дэлхийн хүнсний хангамжид хувь нэмэр оруулах нь үнэхээр эрхэм бөгөөд гайхалтай хүсэл эрмэлзэл гэж би бодож байна. НҮБ-ын ХХААБ энэ зорилгыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ хүсэл тэмүүллийг биелүүлэх асар их нөөц боломж Монголд бий. Эдгээр гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү

өртгийн сүлжээг илүү үр ашигтай болгох, логистикт хөрөнгө оруулалт хийх, үнийг ил тод болгох, хүнсний бүтээгдэхүүний брэндийг сайжруулах, экспортыг дэмжих гэх мэт олон ажил хийх шаардлагатай байгаа нь мэдээж. Тиймээс тодорхой цаг хугацаа шаардагдана. Гэхдээ сайн мэдээ гэвэл бид бүгд нэгэн зорилго урдаа тавьсан тул тэр чиглэлд хөдлөх боломжтой болсон.

- Монголчуудын хүнсний хэрэглээ, соёл, үйлдвэрлэлийн талаар та ямар бодолтой явдаг бол... Бид эрүүл, тэжээллэг хүнс хэрэглэж, үйлдвэрлэж чадаж байгаа болов уу?

Монголд хооллолтын чанар, төрөл зүйлийг сайжруулахын тулд олон ажил хийх шаардлагатай байна. Одоогоос таван жилийн өмнө хийсэн хоол тэжээлийн үндэсний судалгаагаар тав хүртэлх насны хүүхдүүдийн 90 хувь нь Д аминдэмийн дутагдалтай, жирэмсэн эмэгтэйчүүдийн 95 хувь, эрэгтэйчүүдийн 82 хувьд Д аминдэмийн хэмжээ хангалтгүй байсан. Тав хүртэлх насны хүүхдийн А аминдэмийн дутагдлын тархалт 9.5 хувь байна. Нярай хүүхдүүд болон жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд цус багадалт, төмрийн дутагдал 20-30 хувьтай



Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, дэлхийн хүнсний хангамжид хувь нэмэр оруулах нь үнэхээр эрхэм бөгөөд гайхалтай хүсэл эрмэлзэл гэж би бодож байна. НҮБ-ын ХХААБ энэ зорилгыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ хүсэл тэмүүллийг биелүүлэх асар их нөөц боломж Монголд бий”

байгаа тааруу үзүүлэлтүүд байна. Саяхан улсын хэмжээнд нөхөн үржихүйн насны эрчүүд, эмэгтэйчүүд дунд явуулсан судалгаагаар жимс жимсгэнэ, булцуугүй хүнсний ногоо, өндөг, самар, бүхэл үр тариа зэрэг эрүүл хүнсний бүлгийн хэрэглээ бага байгааг тогтоожээ. Бичил элементийн дутагдал нь зүрх судас, бодисын солилцооны өвчлөлийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Улс орнуудын хоолны дэглэм болон халдварт бус өвчний эрсдэлийг





“
Монгол Улс эрүүл хооллолтын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл хооллолтыг илүү хүртээмжтэй, хямд болгоход дорвитой хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Монголд эрүүл хооллох боломж үнэхээр дутмаг, хүмүүсийн бараг 50 хувь нь эрүүл хооллох өртгийг төлж чадахааргүй байна”

харьцуулсан дэлхийн судалгаагаар Монгол Улс хоол тэжээлийн тэнцвэргүй байдлаас үүдэлтэй зүрх судасны өвчлөлийн нас баралтын хувиар бүх улс орнуудын дунд Нэгдүгээр байрт оржээ. Тэгэхээр эрүүл хооллолтын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл хооллолтыг илүү хүртээмжтэй, хямд болгоход дорвитой хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Монголд эрүүл хооллох боломж үнэхээр дутмаг, хүмүүсийн бараг 50 хувь нь эрүүл хооллох өртгийг төлж чадахааргүй байна.

- *Хүнсний хэрэглээтэй холбоотойгоор аюулгүй байдлын асуудал байнга яригддаг. Монголд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай гэж та үзэж байна вэ?*

Монголд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал бол ноцтой асуудал юм. 2018-2019 онд

халдварт өвчний бүртгэгдсэн тохиолдол 7.5 хувиар өссөн. Бодит байдал дээр суулгалт, хоол хүнсээр дамжих нянгийн халдварын талаар үнэн зөв мэдээлдэггүй, халдварт өвчин өргөн хүрээнд дэгдсэний дараа л мэдээлж, оношилдог. Тэгэхээр тоо баримтад мэдээлэл дутуу бүртгэгдсэн байх магадлалтай. Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 хувийг мал аж ахуй эзэлдэг тул энэ салбар хүнсний аюулгүй байдлын асуудалд голлох анхаарлыг татдаг. Монгол оронд мал аж ахуй өндөр ач холбогдолтой монголчуудын хооллолтод мах, сүүн бүтээгдэхүүн зонхилдог тул эдгээр хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын эрсдэл нь эргээд хүний эрүүл мэндэд ихээхэн аюул учруулж болзошгүй. Мөн энэ нь мал аж ахуйн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварт нөлөөлдөг. Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын асуудалд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Нэгдүгээрт, хяналтгүй уламжлалт нядалгаа, мөн хэрэглэгчид шинэ махыг илүүд үзэж хүнсний чанар, аюулгүй байдалд төдийлөн анхаарал хандуулдаггүй нь бүтээгдэхүүний аюулгүй байдлын хэм хэмжээг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Цаашлаад энэ нь хүнсний аюулгүй байдал, чанарыг сайжруулахад чиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтад саад болдог. Хоёрдугаарт, хүн амын нягтаршил бага, тээврийн дэд бүтэц муу байгаа нь мал эмнэлгийн

үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулж байна. Мал эмнэлгээр төвөггүй үйлчлүүлэх боломжгүй, нэмэлт үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байдаг. Гуравдугаарт, малчдын дийлэнх нь жоргүй эм худалдан авч, хяналтгүй эм, антибиотикийг малдаа хэрэглэдэг. Энэ нь бичил биетний тэсвэржилт үүсэх аюулыг заналхийлж байна. Хэдийгээр бодлого боловсруулагчид болон олон нийтийн дунд бичил биетний тэсвэржилтийн талаарх ойлголт нэмэгдэж байгаа ч хязгаарлагдмал байна. Байгалийн усны нөөцөд найдах нь хүнсний аюулгүй байдлын бас нэг асуудал юм. Хөдөөгийн хүн амын дөнгөж 6.8 хувь нь төвлөрсөн усан хангамжтай бөгөөд малчин өрхүүд ихэвчлэн гүехэн худаг, бүх мал амьтан хэрэглэдэг байгалийн усны эх үүсвэрийг ашигладаг. Монголын зарим тариалангийн талбайд пестицид, гербицидийг хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдлууд бүртгэгдсэн байдаг. Ил усны нөөцийг хэрэглэх, малын ялгадсыг түлш болгон ашиглах нь зоонозын болон гельминтийн халдвар тарах өндөр эрсдэлтэй. Бодлогын тал дээр үндэсний хүнсний хяналтын тогтолцоо, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын стандартын хэрэгжилт аль аль нь хангалтгүй байна. Цаг үетэйгээ нийцэхгүй болсон хууль тогтоомж, тодорхойгүй харьяалал, тандалт, хяналт, хэрэгжилтийн сул талууд бий. Техник, үйл ажиллагаа, санхүүгийн чадавх дутмаг байгаагаас хүнсний аюулгүй байдлыг

“
Боловсролын хөтөлбөрт хоол хүнсний талаарх агуулгыг тусгах нь хэрэглэгчдийн мэдлэг мэдээллийг сайжруулж, хүний эрүүл мэндэд аюулгүй хүнсний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр үзүүлнэ”

зохицуулах институцын бүтэц сул байна. Хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээлэл нь шинжилгээ, дэд бүтэц хангалтгүй зэргээс шалтгаалан хязгаарлагдмал байгаа нь хүнсний аюулгүй байдлын протоколын хэрэгжилтийг доройтоход хүргэж байна. Иймд хүнсний аюулгүй байдлын талаарх эрүүл мэндийн бодлогыг бэхжүүлэх, үүнд хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналт, стандартын тогтолцоог сайжруулах, гарал үүслийг тогтоох шинжилгээ гэрчилгээжүүлэлт, тандалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Боловсролын хөтөлбөрт хоол хүнсний талаарх агуулгыг тусгах нь хэрэглэгчдийг мэдлэг мэдээллийг сайжруулж, хүний эрүүл мэндэд аюулгүй хүнсний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр үзүүлнэ. Ингэснээр хэрэглэгчид өөрсдөө хяналт шинжилгээ шаардаж, илүү ил тод мэдээллийг эрэлхийлэх болно.

- *Цаг зав гарган ярилцсан Ноён Винод Ахужа танд баярлалаа. Таны ажил үйлсэд өндөр амжилт хүсэн ерөөе.*

Та бүхэнд бас баярлалаа. Монголчууд хүнсний хангамж, аюулгүй байдалдаа анхаарч, хувьсгал хийж, Монгол хүн нэг бүр хоол, хүнснээс шалтгаалсан өвчлөлгүй, эрүүл энх байх болтугай.



ХОРТ ХАВДАР БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХООЛ, ХҮНС

Жил ирэх тусам хорт хавдар хүн төрөлхтний эрүүл мэндэд хамгийн хүчтэй заналхийлсээр байна. Энэ аюулт өвчин нь ихэнх тохиолдолд бидний амьдралын хэв маяг, идэж, хэрэглэсэн бүтээгдэхүүнүүд, хүнснээс хамаардаг. Мөн тухайн хүний ген, удамшлаас хамаарах тохиолдол ч бий. Тиймээс бид энэ удааг дэлхийн хорт хавдар судлалын томоохон эрдэмтэд, судлаачдын гаргасан хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг хоол, хүнсний жагсаалтыг танилцуулж байна.



ЭЛСЭН ЧИХЭР

Хэт их чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэх нь зөвхөн чихрийн шижинд ч биш хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг судлаачид тогтоожээ. Шинэ Хорт хавдрын эс нь элсэн чихрээр хооллож, тархалтаа нэмэгдүүлэх, идэвхжих түлшээ болгон ашигладаг болох нь тогтоогдсон байна. Бельгийн молекул биологи судлаач Жонан Твелеин элсэн чихрийн хэт их хэрэглээ нь хорт хавдрын гиперфикаци эсийг хооллож, тархалтыг нэмэгдүүлэх гол хөдөлгүүр болдог" гэв.



СОГТУУРУУЛАХ УНДАА

Согтууруулах ундаа нь элэг, хөх, бүдүүн гэдэсний хорт хавдрын эх үүсвэр болдог. АНУ-ын Үндэсний хорт хавдрын хүрээлэн хүн хэдий чинээ архи ууна, тэр хэрээр өвчлөх магадлал ихэснэ" хэмээн мэдээлжээ. Түүнчлэн дэлхийн 195 оронд хийсэн судалгаагаар архинд донтсон 50-аас дээш насны хүмүүсийн 50 хүн тутмын нэг нь хорт хавдартай байжээ.

БОЛОВСРУУЛСАН ХООЛ ХҮНС

Хуванцар, гялгар баглаатай, агаар оруулахгүйгээр савласан бүтээгдэхүүнүүд/чипс, жигнэмэг, давсалсан самар, хатаамал/ нь түр зуурын өл дардаг байж болох ч нууцаар таны биед хорт хавдрын эс идэвхжих эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг Францын эрдэмтэд нотолжээ. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ хэдэн сар, жилээр шинэ мэт хадгалахын тулд найрлагад нь их хэмжээний химийн гаралтай тогтворжуулагч хийдэг аж. Энэ бодис нь хуванцар баглаа боодолтой нэгдэн урвалд орж, эрсдэлийг улам бүр нэмэгдүүлдэг байна.



ИЛ ГАЛ ДЭЭР ШАРСАН МАХ

Мах, махан бүтээгдэхүүнийг ил гал дээр шарах үед гетероциклины аминууд буюу HCAs, полисоксиолины нүүрс устөрөгчид, эсвэл PAHs гэж нэрлэгддэг нэгдлүүд бий болдог бөгөөд АНУ-ын Үндэсний хорт хавдрын хүрээлэнгийн мэдэгдсэнээр эдгээр бодисын нэгдлийг хүнсэндээ хэрэглэх нь хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг аж.



ХУВАНЦАР

Хуванцар савыг үйлдвэрлэхэд ашигладаг нийлэг бодис эстроген нь хорт хавдар үүсгэгч бодис агуулдаг эсэх тухай эрдэмтэд олон жил маргаж байна. Зарим эрдэмтдийн үзэж буйгаар хуванцар сав, баглаа боодол нь нойр булчирхай, хөхний хорт хавдар үүсгэгч гол шалтгаануудын нэг болдог гэнэ.

ТАРГАЛАЛТ

Ихэнх таргалалт нь бидний хоол хүнсний зохисгүй хэрэглээнээс болж үүсдэг байна. Таргалалт нь хөх, бүдүүн гэдэс, шулуун гэдэс, улаан хоолой, бөөр, нойр булчирхай зэрэг төрөл бүрийн хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

БОЛОВСРУУЛСАН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН



ДЭМБ-аас хотдог, хиам, гахайн утсан мах зэрэг боловсруулсан махан бүтээгдэхүүн хорт хавдрын эрсдэл үүсгэдэг болохыг баталжээ. Тухайлбал, дээрх

бүтээгдэхүүнүүдийн хадгалалтыг уртасгахын тулд давсалж, утаж, их хэмжээний химийн бодис хэрэглэдэг нь ходоод, нойр булчирхай, түрүү булчирхайн хорт хавдрын үндэс болдог аж. Мөн саяхан АНУ-ын Хөхний хорт хавдрын хүрээлэнгээс хийсэн судалгаагаар эдгээр бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэдэг эмэгтэйчүүдийн 15 хувь нь хөхний хорт хавдар тусах эрсдэл буйг мэдээлжээ.

АКРИЛАМИД

Талх, кофе, шарсан төмс гэх мэт бүтээгдэхүүнийг өндөр температурт чанаж болгох үед акриламид гэх химийн нэгдэл үүсдэг. Энэ нэгдэл нь маш бага тунгаар бол ямар ч хор хөнөөлгүй боловч их хэмжээгээр хэрэглэх нь хорт хавдар үүсгэх эрсдэлийг бий болгодог аж.



ДАВСАЛСАН, УТСАН ЗАГАС, ДАРШИЛСАН ХҮНС

Хятадын алдарт давсалж, утсан загас нь хорт хавдар үүсгэгч нитрит хэмээх бодисыг их хэмжээгээр агуулдаг аж. Энэхүү бодис нь хүний ДНК-г гэмтээж, тархи, хүзүүний хорт хавдар үүсгэдэг. Түүнчлэн даршилсан хүнс ходоод, бүдүүн гэдэсний хорт хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг тухай Английн эрдэмтэд тогтоожээ.



ХҮНЦЭЛ

Бангладеш тэргүүтэй 50 гаруй орны 140 сая хүн ам оршин суудаг бүс нутгийн ундны усанд их хэмжээгээр агуулагддаг хүнцэл нь хорт хавдрын эсийг өдөөгч нэгэн хүчин зүйл аж.

Хорт хавдраас хэрхэн сэргийлэх вэ?

1. Ногоо, жимсийг сайн угааж хальсыг авч байх хэрэгтэй.
2. Шарсан, утсан бүтээгдэхүүнээс илүү чанасан, жигнэсэн, ууранд болгосон хүнс хэрэглэ.
3. Утсан, шарсан махны оронд хатаасан мах хэрэглэх хэрэгтэй. Хэрэглэх хүнснийхээ амт, үнэрт анхаарал хандуул.
4. Муудсан шинж байвал шууд хая.
5. Хатаасан, хөлдөөсөн хүнс нь давсалсан, нөөшилсөн бүтээгдэхүүнээс хамаагүй илүү аюулгүй шинж чанартай.
6. Ногоо болон жимсийг их хэмжээгээр авч болохгүй.
7. Ойрын гурав хоногт хэрэглэх хэмжээнийхийг л авах нь зөв юм.
8. Янз бүрийн хяналт шалгалтад орсон найдвартай бүтээгдэхүүн авч байх.
9. Бүх хүнсээ хөргөгчинд хадгал.
10. Согтууруулах ундаа хэрэглэхээ бүрмөсөн болих, эсвэл хамгийн бага хэмжээгээр хэрэглэх.
11. Биед хуримтлагдсан хортой бодисыг гадагшлуулахын тулд бүхэл үрийн гурил, грейпфрут, ногоон цай, хар цай, дарсан байцаа, далайн байцаа хэрэглэ.

Хүнсний аюулгүй байдлын мэдээллийн товчоон



Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хангамжийн хамгийн сүүлийн үеийн мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Үндэсний статистикийн хорооноос ирүүлснээр уншигч та бүхэнд хүргэж байна.

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2022 оны 11 сарын 08-ны өдрийн мэдээллээр Монгол Улс 401349 тонн үр тариа, 210292 тонн төмс, 136650.9 тонн хүнсний ногоо, 158455 тонн тэжээлийн ургамал, 41279 тонн тосны ургамал хураан аваад байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тарианы ургац 174921 тонноор бага байгаа бол төмс 28616 тонноор илүү, хүнсний ногоо 18292 тонноор нэмэгдсэн үзүүлэлт юм. Тэгвэл тэжээлийн ургамал 113513 тонноор бага байгаа бол тосны ургамал 2640 тонноор нэмэгджээ.
- Манай улс хүн амын хэрэгцээнд нийлүүлж буй хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох малын мах, гурил, төмсөө 100 хувь, харин сүү, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, өндөг, цөцгийн тосоо 49-65 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол загас, шувууны мах, төрөл бүрийн будаа, ургамлын тос, жимс, жимсгэнээ 96-100 хувь импортоор хангаж байгаа аж.
- Бараа бүтээгдэхүүний үнийн хувьд хүнсний гол нэр төрлийн 15 бүтээгдэхүүний үнийг 2020 оны мөн үетэй харьцуулахад 13 хувиас 118 хувиар өссөн байна. Тухайлбал үхрийн мах 13 хувиар, хонины мах 19,7 хувиар, цагаан




будаа 26,6 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн гурил 54,4 хувиар, хоёрдугаар зэрэглэлийн гурил 46,8 хувиар, талхны үнэ 67,0 хувиар, өндөг 35,7 хувиар, ургамлын тос 118,6 хувиар, 1 литр сүү 49,6 хувиар, элсэн чихэр 45,0 хувиар, масло 78,3 хувиар, төмс 74,4 хувиар, байцаа 40,5 хувиар, лууван 63,4 хувиар, сонгино 49,4 хувиар тус, тус өсчээ.

- 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 3.7 мянган тн малын мах, 116.9 мянган тн гурил, гурилан бүтээгдэхүүн, 9.5 мянган тн төрөл бүрийн будаа, 1.7 мянган тн хуурай сүү, 1.2 сая ширхэг өндөг, 2.8 мянган тн ургамлын тос, 26.0 мянган тн төмс, 44.7 мянган тн хүнсний ногоо, 15.9 мянган тн элсэн чихэр, 626.7 тн давсны нөөцтэй байна.
- Хүнсний зохистой хэрэгцээнд тулгуурлан хүнсний нөөцийг тооцвол мах, махан бүтээгдэхүүний 12 хоног, гурил, гурилан бүтээгдэхүүний 156 хоног, төрөл бүрийн будааны 70 хоног, хуурай сүүний 33 хоног, өндөгийн 1 хоног, ургамлын тосны 46 хоног, төмсний 81 хоног, хүнсний ногооны 64 хоног, элсэн чихрийн 180 хоног, давс 23 хоногийн нөөцтэй байна.

Хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн динамик:



Хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн динамик:



Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний нэгжийн үнийн хэлбэлзлийг 1 сар, 3 сар, 1 жил, 2 жилийн өмнөх үетэй харьцуулсан байдал:

Бүтээгдэхүүн	Нэгж	2022/11/4	Үнийн хэлбэлзлийг харьцуулсан байдал (%)				
			2022/10/15	2022/07/25	2022/04/25	2021/11/15	2020/11/15
Үхрийн мах	кг	13186	-4.73	-1.09	1.37	13.0	-9.46
Хонины мах	кг	9754	-2.77	-0.07	-3.87	19.07	-1.17
Цагаан будаа	кг	4645	0	0	-1.35	26.3	18.5
Гурил 1-р зэрэг	кг	2000	6.50	0	4.76	54.4	44.2
Гурил 2-р зэрэг	кг	1432	2.65	0.37	1.88	46.8	41.51
Талх	ш	2145	4.43	0.87	2.81	67.0	42.7
Өндөг	ш	497	3.54	-0.21	-4.74	35.7	16.2
Ургамлын тос	литр	9030	-1.31	0.07	48.95	118.3	62.8
Сүү	литр	2500	0	0	-20.0	49.6	13.2
Элсэн чихэр	кг	3759	0	0	2.95	45.09	31.3
Цөцгийн тос	кг	7450	0	0	12.62	78.2	23.9
Төмс	кг	1480	10.86	-33.4	85.57	74.4	45.2
Байцаа	кг	1892	4.47	-17.54	-28.13	40.5	-11.6
Лууван	кг	2328	8.38	-6.37	28.13	63.4	-13.17
Сонгино	кг	2783	1.83	-3.62	55.58	69.36	4.11

Үндэсний Статистикийн хорооны долоо хоног тутмын үнийн мэдээлэл.

МОНГОЛ УЛСАД АНХ УДАА "ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" ДОР...



УИХ-ын Тамгын газар /2022.09.30/

“
Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төсөлд онцгой ач холбогдол өгч ажиллахаа УИХ-ын дарга Г.Занганшатар илэрхийллээ”

БАЙНГЫН ХОРООДЫН УУЛЗАЛТ



УИХ-ын Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /2022.09.06/

Хүнс гэвэл хөрс, байгаль орчны асуудал зайлшгүй яригдах учир үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, уялдаа холбоотой хамтран ажиллахаа Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг илэрхийллээ.



УИХ-ын Төсвийн байнгын хороо

Уулзалтаар тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж ажиллахаа Төсвийн байнгын хороо илэрхийллээ.



УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо /2022.10.07/

Эдийн засгийн байнгын хороо Санхүү, эдийн засгийн дэмжлэг үзүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх тарифын бус бодлогод анхаарч ажиллана.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УУЛЗАЛТ



Сангийн яам /2022.08.26/

Сангийн яам 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно.



Эдийн засаг, хөгжлийн яам /2022.08.26/

Эдийн засаг хөгжлийн яам хүнсний үйлдвэрлэл явуулах тохиромжтой газруудыг судлан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн ажиллана.



Зам, тээврийн хөгжлийн яам /2022.08.27/

Зам, тээврийн хөгжлийн яам хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр тоноглогдсон тээврийн парк шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажиллана.



Байгаль орчин, аялал жуулчлалын яам /2022.08.29/

БОАЖЯ нь үндэсний хоолны аялал, жуулчлалыг бий болгох, сурталчлах зорилгоор Монголын уламжлалт технологийг ашиглан онцлог бүтээгдэхүүнийг хөгжүүлэх замаар брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, монгол үндэсний хоол, хүнсний сүлжээ байгуулахад хамтран ажиллана.



Боловсрол, шинжлэх ухааны яам /2022.08.22/

Боловсрол, шинжлэх ухааны яам сургуулийн хүүхдийн хоол хүнсний хангамж, аюулгүй байдалд анхаарах, хүнсний эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтран ажиллана.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /2022.11.21/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, бага орлоготой иргэдийн хүнсний хангамжид онцгой анхаарч, хамтран ажиллахаар боллоо.



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /2022.08.25/

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал, хангамжтай уялдуулж үе шаттай нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлж, олон улсын чанар стандартад нийцсэн мах экспортлох, "Мал эмнэлгийн хорио цээрийн дэглэм бүхий эрүүл бүс" байгуулах, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах, ирэх таван жилд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангах зэрэг бодлого зорилтуудыг гарган "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 90%-ийг хангаж ажиллана.



Эрүүл мэндийн яам /2022.08.25/

Нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай 10 гол тусламж үйлчилгээнд хүнсний аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндээ хамгаалахад татан оролцуулах, идэвхжүүлэх ажлууд багтсан байдаг. Тиймээс хүнсний хангамж, аюулгүй байдал нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх чухал хүчин зүйл гэдгийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд онцлоод үндэсний хөдөлгөөнийг Эрүүл мэндийн яам бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийллээ.



Эрчим хүчний яам /2022.08.24/

Эрчим хүчний яам нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангахад хамтран ажиллана.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /2022.08.31/

"Шатахуун, түлшний үнэ тогтворгүй байгаагаас хүнсний салбарт үйл ажиллагаа нь тасалдах эрсдэл тулгардаг тул Засгийн газраас ургац хураалтын үед шатахууны үнийг тогтвортой үнээр нийлүүлэхээр шийдвэрлэсэн нь "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнтэй уялдаж буйг дэд сайд О.Батнайрамдал онцоллоо.



Гаалийн ерөнхий газар /2022.08.22/

Импортын өмнөх хяналтыг чангатгах нь чанарын шаардлага хангахгүй, аюултай хүнс хэрэглэхээс урьдчилан сэргийлэх гол хүчин зүйл. Тээвэрлэлт, хадгалалт, зохистой дадлыг нэвтрүүлэхэд төмөр замын тээвэрт хөргүүртэй, зориулалтын вагонтой болох шаардлагатайг Гаалийн ерөнхий газрын төлөөллүүд онцлов.



Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /2022.09.29/

“
Монгол хүн бүр эрүүл,
аюулгүй хүнсээр
хүртгэмжтэй хангагдах
нөхцөлийг бүрдүүлэхийн
тулд бусад төрийн
байгууллагуудтай уялдаа
холбоотой ажиллана”



Үндэсний статистикийн хороо /2022.08.31/

Үндэсний статистикийн хороо хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах чиглэлээр хамтран ажиллана.



Харилцаа холбооны зохицуулах хороо /2022.08.30/

Харилцаа холбооны зохицуулах хороо нь нийгмийн хариуцлагын хүрээнд бүх телевиз, радиогийн хөтөлбөрт "Хүнсний аюулгүй байдлын цаг" нэвтрүүлгийг 7 хоног тутам тогтсон цагт явуулж ард иргэдийг хоол хүнсний зөв зохистой хэрэглээнд төлөвшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллана.



Монголбанк /2022.08.30/

Монголбанк нь УИХ-аас баталсан 36-р тогтоолын санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдэд хамтран ажиллана.



Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /2022.08.26/

Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд тавих хяналтанд бүх нөөц боломжоо дайчлан ажиллана.



Зээлийн батлан даалтын сан /2022.08.24/

Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай хүнс үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллана.



Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар /2022.09.07/

Газар ашиглалтыг сайжруулах, талбайг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 5,000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулна.



Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн /2022.09.02/

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн дэмжлэг чухал. Тиймээс Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хамт олонтой санал солилцох уулзалт хийлээ.



Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лаборатори /2022.09.03/

ХАБҮЛЛ-тай Улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.



Жижиг, дунд үйлдвэрийн газар /2022.08.25/

Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг ханган, нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж, мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Жижиг, дунд үйлдвэрийн газар дэмжлэг үзүүлж ажиллана. Ингэснээр хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдал бий болж, төвлөрөл саарч мал аж ахуй, газар тариалангийн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл хөгжиж, шинэ ажлын байр нэмэгдэх юм.



Хөдөө аж ахуйг дэмжих сан /2022.09.02/

“
Хөгөө аж ахуйг дэмжих сан нь
хүнс, хөгөө аж ахуйн салбарын
бодлогын удирдамж, үндсэн
чиглэл, хөтөлбөр, төслийг
хэрэгжүүлэхэд шаардагдах
санхүүгийн нөөцийг бүрдүүлж,
зөв зохион байгуулалттайгаар
хуваарилах замаар хөгөө аж
ахуйн үйлдвэрлэлийн эдийн
засгийн үр ашгийг дээшлүүлэхэд
дэмжлэг үзүүлнэ”



Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар /2022.08.27/



Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төв /2022.09.15/



НЗДТГазар болон Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /2022.10.19/

Хүн амын гуравны нэг нь амьдардаг Улаанбаатар хотын удирдлагуудтай нийслэлийн нээлтийн арга хэмжээний талаар зөвлөлдөж, "Smart urban green city" буюу ухаалаг хүлэмжид суурилсан агро сити байгуулах төсөл бусад арга хэмжээний талаар санал солилцов.




Мал эмнэлгийн ерөнхий газар
/2022.08.23/

Мал эмнэлгийн ерөнхий газар Монгол Улсыг ирэх таван жилийн хугацаанд малын гоц халдварт өвчингүй эрүүл, тайван улс гэдгийг баталгаажуулна.



Стандарт, хэмжил зүйн газар
/2022.08.22/

Стандарт, хэмжил зүйн газар хүнс, хөдөө аж ахуйн салбарын стандартыг хангах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүнс үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд анхаарна.



МҮОНРТ /2022.09.07/

Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн ажлыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хийж хэрэгжүүлнэ.



ХААИС /2022.09.01/

Хөдөө аж ахуйн их сургууль нь хүнс үйлдвэрлэл, шинэ сорт нутагшуулах, техник технологи, механикжуулалт бий болгох, чадварлаг хүний нөөц бүрдүүлэхэд хамтран ажиллана.



Үндэсний итгэмжлэлийн төв
/2022.11.22/

Үндэсний итгэмжлэлийн төвтэй хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



Ургамал газар тариалангийн хүрээлэн
/2022.10.17/

Дотоодынхоо хүнсний хэрэгцээг бүрэн хангах, газар тариалан, хөдөө аж ахуйн салбарыг "шинжлэх ухаанчаар" хөгжүүлэхэд Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн үйл ажиллагаа, оролцоо нэн чухал юм. Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн харьяа "Ургамал газар тариалангийн хүрээлэн" энэ хүрээнд үндэсний хөдөлгөөнийг дэмжих ажиллана.

Олон улсын байгууллагуудын уулзалт



НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар /2022.09.22/

НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар хөдөө аж ахуйн салбарт олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнтэй нягт уялдан ажиллах юм. Тус байгууллага нь цар тахал, мөргөлдөөний үр нөлөөнд өртөж буй хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, сэргээхэд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлж, ойрын хугацаанд үйл ажиллагаагаа улам өргөжүүлэх төлөвлөгөө, эрмэлзэлтэй байна.



JICA-ын Монгол дахь төлөөлөгчийн газар /2022.09.16/

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ нь аялал жуулчлал, хувийн хэвшлийн салбаруудад түлхүү дэмжлэг үзүүлж, төсөл, хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг нэмэгдүүлнэ.



НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага UNIDO /2022.11.22/

НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагатай "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд тусгагдсан ажлуудаас хамтарч хэрэгжүүлэхээр хэлэлцэв.



БНСУ-ын Корея төлөөлөгч байгууллага /2022.09.16/

БНСУ-ын хөдөө аж ахуйг дэмжих газрын харьяа КОПИА Монгол төв нь 2022–2025 онд Мал аж ахуй эрхлэгчдийн тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах загвар бий болгох төслийг хамтран хэрэгжүүлэх аж. "Хүнсний хувьсгал" өрнөснөөр төсөл хэрэгжүүлэхэд хялбар болж буйг тус байгууллагын захирал Чой Ман Ёон уулзалтын үеэр хэлж байлаа.



Koica-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар /2022.11.09/

Хөдөө аж ахуйн салбарт боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтарч ажиллахаа Койка-ийн Монгол дахь Суурин төлөөлөгч Ким Жүн Му онцлон хэллээ.



Европын холбооноос Монгол улсад суугаа төлөөлөгчийн газар /2022.09.30/

Европын холбооноос Монгол Улсад хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр төслүүдээр хамтын ажиллагаа хязгаарлагдахгүй. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд сэргээгдэх эрчим хүчний асуудлыг бүрэн шийдсэн байх шаардлагатай. Учир нь энэ чиглэлээр хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.



Дэлхийн банк /2022.09.08/

Дэлхийн Банк Группын гишүүн Олон Улсын Санхүүгийн Корпораци "Монгол мах" төслийг хэрэгжүүлж байна. Монгол махны экспортын 95 хувь нь Хятад руу гардаг бөгөөд тус улс дотоодын хүнсний аюулгүй байдалд онцгой анхаарах болсон. Тиймээс Хятад улсын тавьж буй стандартыг хангаж чадвал бусад оронд ч махаа экспортлох боломжтой гэдгийг уулзалтын үеэр онцолж байв.



Азийн хөгжлийн банк /2022.09.14/

Азийн Хөгжлийн Банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар нь УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



Япон улсын "Octo Force Management" компани /2022.09.06/

Японы "Окто Форс Менежмент" компани нь Монгол улсын хүнс үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийх нарийн төлөвлөгөөг боловсруулан хамтран ажиллахаа илэрхийллээ. Түүнчлэн орон нутгийн хүнс үйлдвэрлэл, тээвэр ложистикийн салбарт 150-200 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой.



Монгол Улс эрүүл хооллолтын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл хооллолтыг илүү хүртээмжтэй, хямд болгоход дорвитой хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Монголд эрүүл хооллох боломж үнэхээр дутмаг, хүмүүсийн бараг 50 хувь нь эрүүл хооллох өртгийг төлж чадахааргүй байна"

Бэлтгэсэн: Р.Будмаа, Г.Лхагвадулам,
Б.Урантуяа, Д.Намуун



Канад Улсын Элчин Сайдын яамны Худалдааны төлөөлүүд /2022.10.21/

Канад Улсын Элчин Сайдын яамны Худалдааны төлөөлүүдтэй уулзаж, УИХ-ын 36-р тогтоолын талаар танилцуулж, хамтын ажиллагааны талаар санал солилцов.



ДЭЛХИЙН БАНКНЫ
МОНГОЛ УЛСЫГ
ХАРИУЦСАН СУУРИН
ТӨЛӨӨЛӨГЧ НОЁН
Андрей Михнев



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн нь олон улсын болон Монгол Улсын хувьд цаг үеэ олсон санаачилга хэмээн бид харж байна. Ялангуяа хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулах, хүнсний салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн эрүүл мэндийг дээшлүүлэх зорилгоор чадавч бэхжүүлэх зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь Монгол оронд нэн тулгамдсан асуудлыг шийдэх гарц гэж харж байна. Мөн малын өвчингүй статусыг баталгаажуулах, ирэх 5 жилийн дотор 19 гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн бөгөөд тогтвортойгоор хангадаг болох, Монгол Улсыг бүс нутагтаа хүнс экспортлогч орон болгох санаачилга нь эдийн засагт цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийн суурь, нөхцөл байдлыг 2030 он гэхэд бодитойгоор бэхжүүлэх, тэлэх зорилго бүхий Эдийн засгийн Шинэ Сэргэлтийн Бодлоготой нягт уялдаж байна.

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг Дэлхийн Банк аналитик судалгаа болон хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтээр дэмжиж байна. Одоо хэрэгжиж буй "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл" нь Монгол Улсын мал эмнэлгийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн, малын халдварт, гоц халдварт, мөн зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор хэрэгжиж буй төсөл юм. Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлыг

дээшлүүлэхэд уг төсөл дэмжлэг үзүүлж, "малчны хотноос эцсийн хэрэглэгч хүртэл", цаашлаад гадаад зах зээлд амжилт олох, өрсөлдөх чадвар бүхий үнэ цэнийн гинжин хэлхээг хөгжүүлэх зорилгоор анхдагч үйлдвэрлэгчид болон хувийн хэвшлийн боловсруулах үйлдвэрүүд, үйлчилгээ үзүүлэгчид хоорондын "бүтээлч түншлэл"-ийг дэмжин ажиллаж байна. Мөн "Экспортыг дэмжих төсөл" нь гадаад зах зээлд гарах явдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж экспортын бараа бүтээгдэхүүний баталгаажилт, чанарын менежментийг дэмжих замаар экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж байна. Харин "Монгол Улсын зам тээврийн холболт, ложистикийг сайжруулах төсөл" нь ложистикийн нэгдсэн, зангилаа төвүүдийг хөгжүүлэх концепцийг дэмжиж буй төсөл бөгөөд махны хэлхээ зэрэг стратегийн ач холбогдолтой үнэ цэнийн гинжин хэлхээг дагасан тээвэр ложистикийн цогц үйлчилгээг бий болгоход анхааран ажиллаж байна.

Дэлхийн Банкны зүгээс "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэхээр зорьж буй хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн үзэл баримтлалтай нягт уялдах, ногоон бөгөөд өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуйг хөгжүүлэх, дэмжих нэгэн шинэ төслийг хэрэгжүүлэхээр судалж байна. Уг төсөл нь цар тахлын дараах үеийн эдийн засгийн сэргэлтийг дэмжээд зогсохгүй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалах аливаа цочрол, хямралыг даван туулах чадварыг бэхжүүлж хүнсний хангамж, экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах юм.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
МОНГОЛ УЛС ДАХЬ СУУРИН
ТӨЛӨӨЛӨГЧ НОЁН
Павит Рамачандран



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Азийн хөгжлийн банк өндөр ач холбогдолтой хэмээн үзэж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөө нь хөдөөгийн хөгжил, хүнсний аюулгүй байдлын асуудлыг тэргүүлэх чиглэлүүдийнхээ нэгээр тодорхойлсон "Азийн хөгжлийн банкны 2030 он хүртэлх стратеги"-тай бүрэн нийцнэ. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаа нь Монгол Улс, Азийн хөгжлийн банкны түншлэлийн стратеги (2021-2024)-т тусгагдсан гол чиглэлүүд буюу малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах, хөдөө аж ахуйн ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээг бэхжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт хамаарах логистикийн тогтолцоонд анхаарал хандуулах, тус салбарын уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлын мөшгөх тогтолцоог дэмжих зэрэг зорилтуудтай уялдана. Хүнсний баталгаат хангамж, аюулгүй байдлыг хангах Үндэсний хөдөлгөөнийг эхлүүлэн өрнүүлэх тал дээр Ерөнхийлөгчийн зүгээс гаргах санал санаачилгыг Азийн хөгжлийн банк бүрэн дэмжиж, шаардлагатай дэмжлэгийг хөгжлийн бусад түншүүдийн хамтаар үзүүлэхэд бэлэн байна. Энэхүү дэмжлэгийн эхний алхам нь шинээр хэрэгжих "Цар тахлын дараах дэлхийн хүнс, бордооны үнийн хямралын үед Монгол Улсын хүнсний хангамжийн баталгаат байдлыг бэхжүүлэх нь" техник туслалцааны төсөл байх бөгөөд уг төслийн үндсэн зорилго нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөдөлгөөнийг хэрэгжилтийг дэмжихэд оршино. Төслийн хүрээнд, төр болон хувийн хэвшлийн олон тооны оролцогчдын харилцан уялдаа, зохицуулалтыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хүнсний баталгаат хангамж, аюулгүй байдал" хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Ойрын хугацаанд Азийн хөгжлийн банк дараах гурван чиглэлд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна. Нэгт, хүнсний хангамжийн мэдээлэл, хариу арга хэмжээний нэгдсэн санг нэвтрүүлэх тал дээр ажиллах болно. Ингэснээр хүнсний хангамжийн баталгаат бус байдал, эрсдэлийн эсрэг засаглалын

шат шатны бодлогын оновчтой зохицуулалтын механизм буй болж нийлүүлэлтийн хэлхээ тус бүрээр хүнсний хангамжийн баталгаат байдал, хүнсний аюулгүй байдлын хяналт мониторинг хийх мэдээллийн нэгдсэн систем бүрдэх юм. Хоёрт, хувийн хэвшлийн түлхүү оролцоо бүхий, орчин үеийн боловсронгуй, мөн сөрөг нөлөөг тэсвэрлэх чадвартай хүнсний гинжин хэлхээг дэмжин ажиллах чадамж бүхий уялдаа холбоотой институцын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож сайжруулах тал дээр УИХ-аас гаргасан шийдвэрүүдтэй дээрх зорилтууд нягт уялдаж байгааг дурдах нь зүйтэй. Эцэст нь, хүнсний хангамжийн логистикийн сүлжээг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтын цогц төлөвлөлтийг хийхэд Азийн хөгжлийн банк дэмжлэг үзүүлэх болно. Засгийн газраас хэрэгжүүлэх хүнсний баталгаат хангамж, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг бодит ажил болгох хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн платформыг байгуулах болно.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй зарим төсөл хөтөлбөрүүд нь шинээр хэрэгжих санаачилга, үйл ажиллагааг дэмжих боломжтой. Тухайлбал "Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан", "Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих замаар амьжиргааг дээшлүүлэх" зэрэг төслүүд нь хүнсний ногоог дотооддоо үйлдвэрлэн, ханган нийлүүлэх шинээр тавьсан зорилготой яв цав нийцэх бол "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төсөл нь хөдөө аж ахуйн бат бэх үнэ цэнийн гинжин хэлхээг хөгжүүлэхийг зорьж байгаа бөгөөд малчид, тариаланчдыг ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний салшгүй хэсэг болгох, олон улсын зах зээлд "Монгол" хэмээх брэндийг бий болгож амжилтад хүргэх зорилготой юм. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарыг дэмжих тал дээр Азийн хөгжлийн банк цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.



НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн
байгууллагын Агро бизнес ба
Дэд бүтцийн хөгжлийн газрын
Хүнсний аюулгүй байдал,
хүнсний системийн хэлтсийн
дарга **Ноён Али Бадарне**



ЮНИДО нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн болон Засгийн газрын тэргүүлэх зорилт "Алсын хараа 2050"-ыг дэмжиж, хамтран ажиллаж байгаа билээ. Түүнчлэн бид Минамата, Стокгольм зэрэг олон улсын холбогдох конвенциуд, Парисын хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд, ялангуяа Аж үйлдвэр, инновац, дэд бүтцийн хөгжлийн 9-р зорилгод хүрэхэд нь Монгол Улсын Засгийн газарт туслахад үргэлж бэлэн байна.

Хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийн хомсдол, үүнтэй холбоотой нийлүүлэлт түгээлтийн сорилтууд, хүнсний тогтолцооны уян хатан байдал, тогтвортой байдлыг сайжруулахад шаардлагатай өөрчлөлт зэрэг нь дэлхий нийтийн анхаарлын төвд байна. Дэлхий дахинд нүүрлэж буй олон хямрал буюу цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, мөргөлдөөн, эдийн засгийн уналтын нөлөөгөөр хүнсний аюулгүй байдлын хэтийн төлөв бүрхэг байгаа. Эдгээр сорилтуудыг даван туулахад ЮНИДО стратегийн гол анхаарал хандуулж, ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор мэдлэг туршлага солилцох, технологи дамжуулах замаар бэлчээр болон тариалангаас эцсийн хэрэглэгчдийн ширээ хүртэл бүх үе шатанд оролцогч аж ахуйн нэгжүүдэд туслах замаар өлсгөлөнг бууруулах явдлыг байгууллагынхаа шинэ тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгосон. Бид хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн болон бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний уян хатан, тогтвортой байдалд нарийвчилсан үнэлгээ хийж, үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хүнсний тогтолцоог үйлдвэрлэлийн эрэлтийн дагуу хөгжүүлэх

чиглэлээр олон ажлуудыг хийж, хэрэгжүүлдэг.

Хүнсний баталгаат байдал бол хүнсний аюулгүй байдлын амин чухал хэсэг. Тиймээс өлсгөлөнг зогсоохоос эхлээд тогтвортой үйлдвэржилт, байгалийн нөөцийг хадгалах хүртэл хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх асуудал бол 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын гол цөм нь юм. Энэ хүрээнд гарах хэтийн үр нөлөө нь хүнсний аюулгүй байдлын эдийн засаг, хүний хөгжлийг дэмжих, тогтвортой байлгах тулгуур багана болгон бэхжүүлж, Эрүүл мэнд, Хөдөө аж ахуй, Худалдаа гэсэн гурван том бодлогын хөтөлбөрийг холбогч хүчин зүйл болгох явдал. Түүнчлэн хүнсний аюулгүй байдлын шилдэг туршлагыг хүнс, хөдөө аж ахуй, хүнсний бизнес эрхлэгчид, хэрэглэгчдийн эрх ашгийн төлөө олон улсын стандарт шаардлагын дагуу хөгжүүлэх, сурталчлах нь хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийн хөгжлийг хурдасгах, дэмжих ЮНИДО-ын эрхэм зорилгын чухал хэсэг бөгөөд энэ нь эргээд Тогтвортой хөгжлийн зорилго болох даван туулах чадвартай дэд бүтцийг бий болгох, хүртээмжтэй, тогтвортой үйлдвэржилтийг дэмжих, инновацыг дэмжихэд гол хувь нэмэр оруулна. ЮНИДО-ын Хөдөө аж ахуйн бизнес, дэд бүтцийн хөгжлийн газар ба түүний Хүнсний аюулгүй байдал, хүнсний тогтолцооны хэлтэс нь дээрх чиглэлээр ажилладаг тус байгууллагын гол хөдөлгөгч хүч юм. Манай байгууллага Монгол Улсын төрийн тэргүүний санаачилсан үндэсний хөдөлгөөнийг өөрийн нөөц бололцоонд тулгуурлан дэмжин ажиллах болно.

Монголын ард түмэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!



"ЖАЙКА"-ГИЙН МОНГОЛ
ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ГАЗРЫН ДАРГА НОЁН
Танака Шиничи



Цаг уурын өөрчлөлт, шатахууны үнийн өсөлт, цар тахлын дэгдэлт, Европын бүс нутагт үргэлжилж буй мөргөлдөөн, хөрш улсын хил орчмын бөөгнөрөл зэрэг асуудлуудаас шалтгаалж Монгол улсын хүнсний хангамжийн сүлжээ алдагдахад хүрсэн билээ. Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах арга хэмжээг Монгол улсын Засгийн газар нэн тэргүүнд тавьж зарим арга хэмжээг авч эхлээд байна.

Индонезийн Бали хотноо энэ жилийн G20-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр гол хөтөлбөрийн нэг нь "Хүнсний аюулгүй байдал болон эрчим хүчний аюулгүй байдлын талаар" байсан юм. G20-ийн орнууд, түүний дотор Япон улс хөдөө аж ахуй, хүнсний нийлүүлэлтийн системд хүлэмжийн аж ахуй, шинэ инновацын технологийг нэвтрүүлэх, жижиг дунд фермерүүдийн орлогыг дээшлүүлэх зэрэг шинэлэг технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна.

Монгол улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар тус салбарыг хүчирхэг болгох, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангахад чиглэсэн "ХАА-н салбарын нэмүү өртгийн мастер төлөвлөгөө боловсруулах" төслийг ЖАЙКА нь 2020 оны 12 сараас 2024 оны 2 дугаар сар хүртэл хэрэгжүүлэх юм. Төслийн хүрээнд хүнсний ногоо, тосны ургамал, чацаргана, зөгийн бал, мөөг, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, сарлагийн хөөвөр, ноос ноолуур, загас боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүн зэрэг туршилтын төслүүдийг хэрэгжүүлж байна. Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлогч улс болох зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөдөө аж ахуйн экспортын чадамжийг тодорхойлж, бизнесийн кластер байгуулах, бүтээгдэхүүн тус бүрийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, кластер байгуулах үйл ажиллагааг дэмжих мөн чадавхжуулах зэрэг дэмжлэг үзүүлж байна. Төслийн хүрээнд боловсруулах Мастер

төлөвлөгөө болон туршилтын үйл ажиллагааг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон хөдөө аж ахуйн талаарх бодлогын баримт бичгүүдэд тусгахаар ажиллаж байгаа бөгөөд Хүнсний хангамж аюулгүй байдлын талаар авах арга хэмжээнүүдэд хувь нэмэр оруулах юм. Мөн экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих, экспортоор дамжаад гадаад валютыг дотооддоо татах зэрэгт эерэг нөлөө үзүүлэх юм.

Цар тахал дэгдэхээс өмнө Монгол Улсын хүн амын ойролцоогоор 40 хувь нь эрүүл бус хооллолттой байна гэсэн статистик гарсан. Эрүүл, шим тэжээлтэй хүнсний дутагдал нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйгөөс гадна жингийн илүүдэл, шим тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр "Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих" төслийг ЖАЙКА-с хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд жижиг дунд фермерүүд болон орон нутгийн иргэдийн эдийн засгийг төрөлжүүлэх, хоол тэжээл, хөдөө аж ахуй, нийгмийн хамгааллын хоорондын уялдаа холбоог ханган сургуулийн үдийн хоолны хөтөлбөрөөр дамжуулан Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлын талаарх үндэсний хөдөлгөөнд хувь нэмэр оруулан ажиллаж байна. Түүнчлэн хүнс хөдөө аж ахуйн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэн чухал бөгөөд энэ салбар хөгжих боломж бүрэн бий. Жижиг дунд үйлдвэрлэл болон хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн тогтвортой урт хугацааны хүнс хөдөө аж ахуйн системийг бий болгоход чиглэсэн хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ЖАЙКА нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа. Дээр дурдсан төслүүдээс гадна Монгол Улсын үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөдөө аж ахуйн салбарт олон төрлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байгаа билээ. Цаашид ч Монгол Улсын Хүнсний хангамж, аюулгүй байдлын хэрэгжилтэд хувь нэмэр оруулан ажиллах болно.



КОПИА МОНГОЛ
ТӨВИЙН ЗАХИРАЛ НОЁН
Чой Ман Ён



Монгол Улс Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын төлөөх үндэсний хөдөлгөөнд үнэнчээр зүтгэж байгаад Солонгосын Хөдөөгийн хөгжлийн дэмжих газрын нэрийн өмнөөс болон Копиа Монгол төвийн захирлын хувьд чин сэтгэлээсээ, талархал илэрхийлье.

Монгол Улс газар тариалангийн, ялангуяа хүнсний ногооны үйлдвэрлэлийн тогтолцоо байхгүйгээс цар тахлын дараа хүнсний ногооны хангамж нийлүүлэлтийн хувьд томоохон сорилтуудтай тулгарч байгаа ч энэ хүнд цаг үеийг ард түмэнтэйгээ хамтран даван туулж буй. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөдөлгөөн бол цаг үеэ олсон үйл явдал гэж үзэж байна. Копиа Монгол төвөөс шинээр эхлүүлэн хэрэгжүүлж байгаа загвар сум төсөл нь үндэсний хөдөлгөөнтэй уялдана. Төслийн зорилго нь малчдыг чанартай тэжээл үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой мал аж ахуйг дэмжих бөгөөд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран амьжиргааг сайжруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйнуудад тэжээлийн ургамлаа тарьж, ургуулах технологийг нэвтрүүлэх юм. Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран Сэлэнгэ аймгийн

Сант сум, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Төв аймгийн Аргалант сум, Партизаны сүүний болон махны үхрийн аж ахуй эрхэлдэг нийт 80 өрхөд ферментжүүлсэн бүрэн найрлагат багсармал тэжээлийг нийлүүлж байна. Ийн эрчимжсэн газар тариалан эрхлэлт, фермийн аж ахуйг дэмжин сайн чанарын үхрийн мах, сүү бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, технологийг сайжруулж, тэжээлийн ач холбогдлын талаар мэдлэгтэй болохоос гадна ойролцоо фермерүүдэд энэ туршлагаа өргөнөөр нэвтрүүлж, тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгоход тусална гэж найдаж байна.

Монгол Улс бусад орнуудыг бодвол тэжээлийн ургамлын тариаланг хөгжүүлэх боломж бүхий өргөн уудам, үржил шимт баялаг газар нутагтай төдийгүй хөдөлмөрч ард иргэдтэй гэж би боддог. Копиа Монгол төв нь 2024-2028 онуудад хэрэгжүүлэх гурав дахь шатны хөтөлбөрийг бэлтгэж эхлээд байна. Бид Монгол дахь хүнсний хэрэглээний хангамж, хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хүнсний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж, хамтран ажиллах болно.

Малыг эрүүл байлгахын тулд дархлаажуулах нь чухал



Монгол Улсын мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, сонгосон бүс нутгуудад хил дамжин халдварлах өвчингүй бүсийг бий болгоход хувь нэмэр оруулах зорилготой “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөлд НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага техник, тоног төхөөрөмжийн тусалцаа үзүүлж байна”

Дэлхийн банкны санхүүжилтээр 2020 оны 06 дугаар сараас хэрэгжиж буй уг төслийн “Малын эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг” хүрээнд шүлхий өвчинтэй тэмцэх, тандалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Мал эмнэлгийн ерөнхий газартай нягт хамтран ажиллаж, чамгүй олон ажлыг хийж, хэрэгжүүлээд байна. Хил дамжин халдварладаг өвчнүүдийн дэгдэлтийн улмаас малын гаралтай бүтээгдэхүүний экспорт хязгаарлагдмал байгаа энэ үед мал сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой хэрэгжүүлэх нь малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.



Шүлхий өвчний тухай

Шүлхий өвчин нь үхэр, гахай зэрэг салаа туурайт амьтанд халдварладаг халуун температурт хурдан нэмэгдэж, хоолонд муу болох ба хүндээр өвдөх, үхэх аюулд хүргэдгээрээ Монгол Улсын хувьд нэгдүгээрт орох, хил дамжин халдварладаг малын гоц халдварт өвчин юм. Энэхүү өвчин нь хэдийгээр хүнд халдварладаггүй ч иргэдийн амьжиргаа, зах зээлд нөлөөлөх замаар эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг. Түүнчлэн шүлхийгээр өвчилсөн малын сүүний гарц огцом багасдаг тул малчин өрхийн хүнсний үйлдвэрлэл буурч, улмаар орлогод ч сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Түүнээс гадна ихэнх малчид мал нь өвдөхөд антибиотик өгдөг. Гэтэл малд өгсөн эм бэлдмэл нь малын биеэс бүрэн гадагшилж дуусаагүй үед хүнсэнд хэрэглэгдэж, эмийн үлдэгдэлтэй мах, сүү хэрэглэсэн хэрэглэгч



эрүүл мэндийн хувьд эрсдэлд орох магадлал өндөр байдаг байна. Тиймээс малыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх нь мал сүргийг эрүүл байлгах гол үндэс нь бөгөөд халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зургаан сар тутам хийх нь оновчтой гэж үздэг.

Дархлаажуулалтын ажил

Өнгөрсөн жил Монгол Улсын хэмжээнд шүлхий өвчний дэгдэлт нэмэгдэж нийт 330 сумын 98-д нь бүртгэгдээд байсан үед зөвхөн “үхэр болон сарлаг”-ийг дархлаажуулах стратегийг хэрэгжүүлэхэд “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслөөс дэмжлэг үзүүлсэн. Үхэр, сарлаг зэрэг бод мал нь бог малтай харьцуулахад халдвар ихээр тараадаг онцлогтой. Монгол Улс 70 гаруй сая толгой шүлхийд мэдрэмтгий малтай (үхэр, сарлаг, хонь, ямаа, тэмээ) учраас мал сүргийг бүрэн дархлаажуулах вакцины нөөц хангалтгүй байв. Харин бод малын тоо толгой 5.5 сая тул зөвхөн “үхэр болон сарлаг”-ийг дархлаажуулах стратегийг Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэн ажилласан юм. Тус стратеги нь шүлхийтэй тэмцэх хамгийн үр дүнтэй, зардал багатай арга байсан билээ. Бод малын шүлхийн өвчлөлийг бууруулах зорилгоор “Үхэр болон сарлаг”-ийг дархлаажуулах ажлыг 2022 оны 4 сараас эхлүүлсэн төдийгүй дархлаажуулалт эхлээд 4 долоо хоногийн дараа шүлхий өвчний өдөрт илрэх тохиолдол эрс буурсан. Тэгвэл хоёр дахь дархлаажуулалтын ажил нь 2022 оны 10 дугаар сард хийгдэж дуусаад байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Мал эмнэлгийн ерөнхий газрын хүсэлтийн дагуу 2023 оны хаврын дархлаажуулалтад зориулж “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг



нэмэгдүүлэх” төслөөс 1.9 ам сая долларын өртөг бүхий 6.5 сая тун шүлхийн вакциныг хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна. Тус шүлхийн вакцин 2022 оны 11 сарын 04-ний өдөр Монгол Улсад ирсэн бөгөөд одоогоор Биокомбинатад хадгалагдаж байгаа юм.

Эх сурвалж: “МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл

Уур амьсгалын өөрчлөлт ба бидний амьдрал

“
Уур амьсгалын
өөрчлөлтийн үндсэн
шалтгаан нь хүний
үйл ажиллагааны
улмаас дэлхийн
агаар мандал дахь
хүлэмжийн хийн
ИХСЭЛТ ЮМ”

©FAO

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар ярихаас өмнө цаг агаар, уур амьсгал гэдэг ойлголтыг ялган ойлгох хэрэгтэй. Цаг агаар гэдэг нь тодорхой хугацаа, агшин дахь агаар мандлын физик төлөв байдлыг хэлэх бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Харин тухайн газар нутгийн газарзүйн онцлог, нарны цацраг, агаар мандал, усан мандал, газар бүрхэвч хоорондын харилцан үйлчлэлээр бий болсон цаг агаарын нөхцөлийн хэдэн арван жилийн дундаж статистик горимоор илэрхийлэгдэх агаар мандлын үзэгдлийг тухайн газрын уур амьсгал гэж нэрлэдэг. Нэг үгээр хэлбэл тодорхой газар нутгийн цаг агаарын нөхцөлийн урт хугацааны дунжийг хэлнэ. Харин уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь уур амьсгал байгалийн жам ёсоороо хэлбэлзэх хугацааны туршид хүний шууд болон шууд

бус үйл ажиллагааны улмаас дэлхийн хийн мандлын бүтцэд гарч буй хувьслын дүнд бий болсон өөрчлөлт юм. Уур амьсгалын урт хугацааны өөрчлөлтийн гол параметр нь дундаж температур, хур тунадас байдаг.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандал дахь хүлэмжийн хийн ихсэлт юм. Агаар мандал дахь хийн найрлага нүүрсхүчлийн хий (CO₂), азотлог исэл (N₂O), метан (CH₄), устөрөгч (H), фторт хийн нэгдэл (HFCs, PFCs, SF₆, NF₃) зэрэг олон тооны хийнээс бүрдэх бөгөөд их бага хэмжээтэйгээр оршдог. Агаар мандлын “хүлэмжийн хий” нэмэгдэхийн хэрээр урт долгионы IR дулааны цацраг дахин цацагдаж, дэлхийн агаар мандалд баригдаж, улмаар дэлхийн гадаргуу дулаарахад хүргэдэг.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллүүд цөөнгүй байдгаас дурдвал:

- Биологийн олон янз байдал хомсдох,
- Усны гачаал,
- Газрын доройтол,
- Гамшигт үзэгдлийн эрчим ба давтамж ихсэх зэрэг нь эдийн засаг болон нийгэмд хүчтэй сөрөг нөлөөллийг үзүүлсээр байна.

Монгол оронд хөдөө аж ахуй эрхлэх боломжтой газрын дийлэнх нь "цаг уурын эрс тэс" нөхцөлд байдаг бөгөөд үүнд:

1. Биологийн үржил шим багатай,
2. Мөнх цэвдэгтэй хөрс,
3. Тогтсон газар тариалангийн усалгааны системгүй,
4. Чийгшил бага, хуурай агаартай. Иймээс уур амьсгалын өөрчлөлтөд маш өртөмтгий салбарт тооцогддог учир бид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон сааруулах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай.

Хүлэмжийн хийн ялгарлыг ихэсгэдэг хүний үйл ажиллагаанаас дурдвал мал аж ахуй эрхлэх, газар тариалан эрхлэх, мод бэлтгэх, эрчим хүч үйлдвэрлэх, түлш үйлдвэрлэх зэрэг юм. Дэлхийн агаарын дундаж температур аж үйлдвэржилтийн өмнөх үетэй (1880) харьцуулахад нэг хэмээр нэмэгдсэн байхад манай орны хувьд сүүлийн 80 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.4 цельсийн хэмээр нэмэгдсэн.

Монгол орны хувьд хур тунадасны хэмжээ 7.3 хувиар буурсан, 2020 оны байдлаар нийт газар нутгийн 76.9% нь цөлжилт, газрын доройтолд өртсөн, сүүлийн 10 жилд гамшигт үзэгдлийн тоо 1.5 дахин нэмэгджээ. Уур амьсгалын өөрчлөлт хүний үйл ажиллагааны хам нөлөөгөөр байгаль, цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийн давтамж, эрч хүч ихсэх, экосистем доройтох, усны нөөц хомсдох зэрэг сөрөг үр дагавар гарсаар, цаашид нэмэгдэх хандлагатай байна. Эдгээрийг даван туулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, түүнд дасан зохицож, ногоон хөгжлөөр тогтвортой хөгжихөд дэлхий нийтээрээ хүчин чармайлт гарган ажиллаж байна.

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Парисын Хэлэлцээр нь дэлхийн дулаарлыг хоёр хэмээр бууруулах, цаашлаад 1.5 хэмд хязгаарлах зорилт тавьсан бөгөөд одоогоор дэлхийн 196 улс нэгдэж, эдийн засгийн буюу хүний үйл ажиллагаанаас улбаатай хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр тодорхой үүрэг, амлалт хүлээгээд байна. Харин Монгол Улс тус хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталжээ. Нийт эдийн засгийн 80 гаруй хувь нь уур амьсгалаас шууд хамааралтай манай улсын хувьд голлох салбаруудын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгагдсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох арга хэмжээнүүдийг



тодорхойлон тооцож, "Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт"-ыг тодорхойлж гаргасан.

Мал аж ахуйн салбарын хувьд ган, зудын давтамжолшрох, цөлжилт, хуурайшилт нэмэгдэх, усны нөөц хомсдох зэрэг сөрөг нөлөөллийн улмаас уламжлалт мал аж ахуй эрхлэхэд хүндрэлтэй болсоор байна. Үүний боломжит шийдлүүдийн нэг нь эрчимжүүлсэн мал аж ахуйг өргөжүүлэх юм. Малын тоонд бус ашиг шим, чанарт анхаарч, үр өгөөжийг нэмэгдүүлснээр малчдын орлого өсөж улсын хүнсний аюулгүй байдлыг хангахад чухал алхам болно. Мөн

бэлчээрийн менежментийг сайжруулснаар бэлчээрийн эмзэг, өртөмтгий байдлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлнэ. Ойн аж ахуйн хувьд ой модыг холимогжуулж, нөхөн сэргээх хэрэгтэй. Хэсэгчлэн доройтсон, сүйтгэгдсэн, сийрэг эсвэл нэг төрлийн модноос бүрдсэн ойг олон төрөл, зүйлийн модоор баяжуулснаар байгалийн сэргэн ургалтыг өдөөж, улмаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд илүү тэсвэртэй ойг бий болгоно. Энэ нь цаашлаад уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг болон түймэр, хөнөөлт шавжийн

эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй дасан зохицох арга хэмжээ юм. Эдгээр шийдлүүд нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох буюу өнөөгийн болон ирээдүйн өөрчлөлтөд бэлтгэж цаашдын сөрөг нөлөөллийг багасган хязгаарлах арга хэмжээг хэлнэ. Түүнчлэн бид ирээдүй хойч үедээ ээлтэй дэлхийг өвлүүлэхийн төлөө уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээнд одооноос суралцаж эхлэн өдөр, цаг, минут тутамд дадах хэрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ гэдэг нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл ялгаруулахаас зайлсхийх аливаа хүчин чармайлтыг хэлнэ. Жишээлбэл, дэвшилтэт болон сэргээгдэх эрчим хүчний технологи ашиглах, эсвэл хуучин тоног төхөөрөмжийг эрчим хүчний хэмнэлттэй болгох. Бид өдөр тутмын амьдралынхаа хэмнэлд дэлхийдээ ээлтэй өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй. Автомашин хэрэглэхээс зайлсхийж, алхах эсвэл дугуй унах, цэвэр усаа хэмнэх, мод тарих гэх мэт. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй асуудлуудыг багасгах шийдэл цөөнгүй байгаа ч үүнийг бид нийтээрээ хэрэгжүүлж байж урт хугацаанд үргэлжлэх бодитой үр дүнд хүрнэ. Тиймээс хойч үедээ таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн эх дэлхийг өвлүүлэн үлдээх нь бидний үүрэг юм.

ЭХ СУРВАЛЖ: НҮБ-ын ХХААБ-ын Парисын Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтын хэрэгжилтийг хөдөө аж ахуй, ой, бусад газар ашиглалтын салбарт ил тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх нь" төсөл.




Цахим Хөдөө аж ахуй

Олон улсын хүнс, хөдөө аж ахуйн тогтолцоо нь бизнес эдийн засгийн бусад салбарууд адил улам цахимжиж байна. Цахим технологи, инновацыг ашиглан олон жилийн турш тулгамдаж байсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлүүдийг даван туулж, тогтвортой, хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуйн салбарыг цогцлоох боломж бий. Блокчэйн, зүйлсийн интернэт, хиймэл оюун ухаан, том өгөгдөл, хиймэл дагуул, 5G сүлжээ зэрэг дэвшилтэт технологи нь хүнс, хөдөө аж ахуйн тогтолцоог эрчимтэй өөрчлөх боломжтой. Эдгээр технологид суурилсан цахим хөдөө аж ахуй нь шийдвэр гаргалтыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлж, зах зээлийг тэлэх зэрэг үр нөлөөтэй бөгөөд хүнс, хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

“**Монгол Улсын хувьд хүнс, хөдөө аж ахуйн салбарт цахим технологи, инновацыг нэвтрүүлэхэд чухал ач холбогдол үзүүлж сүүлийн жилүүдэд олон цахим систем, шийдлүүдийг нэвтрүүлж байгаа бөгөөд тогтвортой, дэлхийд өрсөлдөхүйц хөдөө аж ахуйн салбарыг бий болгох, хөгжлийн олон сорилтуудыг даван туулах зорилгоор цахим хөдөө аж ахуйг нэвтрүүлэхээр зорьж байна”**




Цахим хөдөө аж ахуй нь НҮБ-ын ХХААБ-ын Монгол Улсын Засгийн газартай хамтарч баталсан “Хамтын ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан тэргүүлэх таван чиглэлд агуулагдсан бөгөөд техникийн туслалцаа үзүүлэх замаар хүнс, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг хөгжүүлэх, мал болон ургамлын эрүүл мэндийг сайжруулах, мал аж ахуй болон газар тариалангийн бүтээмж, бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог сайжруулах, цаашлаад салбарын мэдээллийг цахим технологи ашиглан боловсруулах ажлууд хүлээж байна. Блокчэйн суурилсан махны үйлдвэрийн үйл ажиллагааны систем, малыг ялган тэмдэглэх, бүртгэлийн систем, ургамлын гарал үүслийн систем, хүнсний ногоо тариаланчдын бүртгэлийн систем, ухаалаг, аналитик хяналтын самбар зэрэг хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй амжилттай цахим жишээ бий.



“**НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “1,000 цахим тосгон санаачилга”-ын хүрээнд Монгол Улсад “Цахим сум санаачилга”-г хэрэгжүүлж байна”**

НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “1000 цахим тосгон санаачилга”-ын хүрээнд Монгол Улсад “Цахим сум санаачилга” хэрэгжүүлж байна. Тус санаачилга нь орон нутгийн цахим шилжилтийг дэмжих зорилготойгоос гадна цахим экосистемийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, орон нутгийн хөгжилд шаардлагатай цахим үйлчилгээг туршин, нэвтрүүлэх билээ. Эцэст нь олон улсад цахим хөдөө аж ахуйн ач холбогдол улам бүр нэмэгдэх чиг хандлагатай байгаа энэ үед тус боломжийг ашиглан салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийг эрмэлзэх нь зүйтэй юм.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хамтран, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын цахилгаан холбооны байгууллагуудын техникийн дэмжлэгтэйгээр “Цахим хөдөө аж ахуйн үндэсний стратеги”-г 2020 онд боловсруулсан. Цахим хөдөө аж ахуйн үндэсний стратеги нь Засгийн газар, олон улсын байгууллагууд болон бусад салбарын оролцогч талуудын цахим хөдөө аж ахуй чиглэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, зохицуулах үүрэг гүйцэтгэж байгаа билээ.





2020 оны байдлаар нийт бэлчээр нутгийн 69 хувьд нь ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн доройтсон байдалтай байна. Бэлчээрийн мониторингийн 2016 оны мэдээллээр, мониторингийн бүх цэгийн 58 хувь нь талхлагдсан, үүний 13.5 хувь нь сул, 21.1 хувь нь дунд зэрэг, 12.8 хувь хүчтэй, 10.3 хувь нь сэргэлтгүй талхлагдсан хэмээн тогтоогджээ. 2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн бөгөөд үүнээс 31.5 хувь нь сул, 22.1 хувь нь дунд, 18.6 хувь нь хүчтэй, 4.7 хувь нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (IPCC)-ны 2007 онд гаргасан үнэлгээний 4-р тайланд хүн төрөлхтөн XVIII зууны дунд үеэс аж үйлдвэрийн хувьсгалыг эхлүүлж газрыг эрчимтэй ашиглах болсон цагаас хойш хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн нь дэлхийн хийн мандлын бүтэц, харьцаа алдагдаж уур амьсгал өөрчлөгдөх нөхцөлийг 90 хувь нэмэгдүүлсэн гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг.



НҮБ-ын хүн амын сангаас дэлхийн хүн ам сүүлийн арван жилд бараг нэг тэрбумаар өсөж 2022 онд 8 тэрбумд хүрсний дөрөвний нэгийг 15-аас доош насны хүүхэд, ердөө наймны нэг хувийг 60-аас дээш насныхан эзэлж, дэлхий нийт хүн амын талаас илүү хувь нь 15-59 насныхан эзэлж байна гэж мэдээлжээ. 2030 онд дэлхийн хүн ам 8.5 тэрбумд, 2050 онд 9.7 тэрбумд, 2100 онд 10.9 тэрбумд хүрэх төлөвтэй байгаа юм.

“2020 оны байдлаар нийт бэлчээр нутгийн 69 хувьд нь ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн доройтсон байдалтай байна”

Хүн ам өсөхийн зэрэгцээ сүүлийн 60 жилд дэлхий дахинаа хотжилт хурдацтай явагдаж, 1950 онд гурван хүн тутмын хоёр нь хөдөөд амьдарч байсан бол өдгөө нийт хүн амын талаас илүү хувь нь хотод амьдрах болсон байна. Хотжих үйл явц цаашид үргэлжилсээр 2030 онд дэлхийн хүн амын 60 хувь нь хот суурин газарт, 40 хувь нь хөдөө амьдарч байх төлөвтэй байна. Өсөн нэмэгдсээр байгаа хүн амыг хотжилт, хэрэглээн дэх хэв маягийн өөрчлөлтөд нь нийцүүлэн хүнсээр хангахын тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай.

Үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжтой газар нутгийн хэмжээ дэлхий дахинаа хумигдаж, доройтсон, усны нөөцийн хомсдол үүсэх болсон, фосфор болон газрын хэвлийн баялгийн хэт олборлолтоос үүдэн хөрсний үржил шим алдагдаж газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж буурч, давтамж, цар хүрээ нь нэмэгдсээр байгаа байгалийн аюулт үзэгдэлд мал аж ахуй, газар тариалан эрхлэгчид хялбар өртөмтгий болсоор байна. Хүн, мал, амьтны халдварт өвчний голомт сэргэх, шинээр өвчин тахал, ургамлын хортон тархах зэрэг эрсдэл, бэрхшээл тулгарсаар байна.

НҮБ-ын ХХААБ-аас 2018 онд гаргасан МАА-н салбарын тоймоор дэлхийн махны хэрэглээ 2030 онд 80 хувиар, 2050 онд 200 гаруй хувиар нэмэгдэх төлөвтэй гэсэн бол дэлхийн сүүний үйлдвэрлэл 2030 онд 2015–2017 оны суурь үзүүлэлтээс 33 хувиар, махны үйлдвэрлэл 19 хувиар нэмэгдэх төлөвтэй байна гэжээ. Үүнтэй зэрэгцэн дэлхийн уур амьсгал эрчимтэй өөрчлөгдсөөр байгаа нь хүнс үйлдвэрлэлийн тулгуур хөдөө аж ахуйн салбарт томоохон сорилт, бэрхшээлийг учруулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөгөөр хөдөө аж ахуйн (мал аж ахуй, газар тариалан)


Дэлхийн бөмбөрцгийн 3.3 тэрбум га буюу хуурай газрын дөрөвний нэг, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 68%-ийг малын бэлчээрт ашигладаг. Энэ нь 343 тэрбум тонн нүүрстөрөгчийг шингээх багтаамжтай ба дэлхийн ойн сангийн нүүрстөрөгчийн нийт хуримтлалаас даруй 50 хувиар илүү юм. Гэтэл 20 хувь доройтсон байна. Монгол орон 110.3 сая га бэлчээр, 1.7 сая га хадлангийн талбайтай, энэ нь хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 96.2 хувийг эзэлдэг.

Дэлхийн хүнс үйлдвэрлэлээс ялгарах хүлэмжийн хий, 2018 он



Эх сурвалж: Our World Data, oxford University

Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлээс ялгарах метан хий, азотын ислийн ялгарал (2018 он; 5.3 Gt CO2eq)



Эх сурвалж: FAOSTAT 2020


Хөдөө аж ахуйн салбарын нийт хүлэмжийн хийн ялгарлын гуравны хоёрыг мал аж ахуйн салбар ялгаруулдаг.

Мал аж ахуйн салбар дотроо мах, сүүний үхрийн аж ахуй салбарын нийт ялгарлын гуравны хоёрыг мөн эзэлдэг. Хивэгч малын гүзээнд тэжээл шингэж исэлдэх явцад үүсэж, хэвлэг хэврэлтээр 95 хувь нь баас ялгадсаар 5 хувь ялгардаг метаны (намгийн) хий нь хүний үйл ажиллагаанаас ялгаруулж буй дэлхийн нийт метаны 39 хувийг, мал аж ахуйн салбарын нийт ялгарлын 44.1% эзэлдэг.

“
FAOSTAT эх сурвалжаар Монгол улсын 2020 оны эцэст тоологдсон 67.0 сая мал Tier-1 түвшний тооцооллоор 634.3 килотонн метан хий ялгаруулсны 39.4 хувь үхэр сүрэгт, 23.7 хувь хонин сүрэгт, 21.9 хувь ямаан сүрэгт 11.6 хувь адуун сүрэгт 3.4 хувь тэмээ сүрэгт тус, тус ногдож байна”

Хөдөө аж ахуйн салбар нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийг ихээр ялгаруулж дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн эрчийг нэмэгдүүлдэг салбар юм. НҮБ-ын ХХААБ-ын статистикийн албанаас гаргасан тооцоогоор 2018 онд дэлхий дахинаа хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй 54 тэрбум тонн нүүрсхүчлийн хийн эквивалент (CO₂eq)-тэй тэнцэх хүлэмжийн хийн ялгарсны 17 тэрбум тонн CO₂ эквивалент буюу 31 хувийг хөдөө аж ахуй-хүнсний салбар ялгаруулсан нь 1990 оноос 16 хувиар өссөн дүнтэй байна.

Малын баас ялгадсаар ялгарах метан хий нь мал аж ахуйн салбарын нийт ялгарлын 5.7%, азотын исэл нь 4.3 хувь болдог. Малын тэжээл тариалах, үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх явцад ялгарах нүүрсхүчлийн хий нь мал аж ахуйн салбарын хүлэмжийн хийн нийт ялгарлын 45 хувийг эзэлдэг. Хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай эрсдэлийг даван туулах, дасан зохицох чадвартай, өсөн нэмэгдэж буй дэлхийн хүн амыг хоол, хүнсээр тогтвортой хангах цогц ойлголтыг “Уур амьсгалд ухаалаг хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан, загасны аж ахуй, ойн аж ахуй)” гэж томъёолон НҮБ-ын ХХААБ-аас 2010 онд дэлхий дахинаа дэвшүүлсэн юм.



Уур амьсгалд ухаалаг хөдөө аж ахуйн эрхлэх гэдэг нь үйлдвэрлэгч (малчин, тариаланч) хэрэглэгчийн эрэлт, таашаалд нийцүүлэн эрүүл, шим тэжээллэг сайтай хүнсийг хүлэмжийн хийн ялгарал багатай арга технологиор үйлдвэрлэж ашиг орлогоо тогтвортой нэмэгдүүлж нийгэм, эдийн засаг, байгаль, цаг уурын хямрал цочролыг даван туулах чадвартай ухаалаг үйлдвэрлэл юм.



Хүнсний баталгаат байдлыг хангах, Хөгжлийн зорилтуудаг хүрэхэд хувь нэмэр оруулах



НҮБ-ын ХХААБ-ын Хөтөлбөрийн
техникийн зөвлөх, доктор
С.Жигжидпүрэв

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор эх орны өнцөг булан бүрээс...

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх "Хүнсний хувьсгал"-ынхаа хүрээнд улсын хэмжээний дөрвөн томоохон зөвлөгөөнийг ивээл дороо зохион байгуулсан билээ. Эх орны өнцөг булан бүрээс ирсэн зочид, төлөөлөгчид салбарынхаа алдаа, оноо, тулгамдаж буй асуудал, гарц, шийдлээ ярилцсан зөвлөгөөнүүдээс энэ удаагийн дугаарын сурвалжилгаа бэлтгэлээ.



"Хүнсний хангамж, аюулгүй байдал-Газар тариалан" үндэсний чуулган

2022 оны 04.13-04.15

Хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудал нь тогтвортой хөгжлийн хамгийн гол суурь баталгаа гэдгийг Төрийн тэргүүн нээлтийн үгэндээ тэмдэглээд манай улс зөвхөн төмс, гурил, махны хэрэгцээгээ л дотоодоос хангаж, хүнсний ногооны 40, будаа, элсэн чихэр, ургамлын тос, жимс, жимсгэнээ 100 хувь гаднаас авч байгаа нь хүнсний хангамж, аюулгүй байдал ямар эмзэг байгаагийн илрэл гэдгийг онцолсон. Түүнчлэн эх дэлхийгээ шүтэн хайрладаг хүн ардтай, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалдаг төр, засагтай "Ногоон Монгол" болох зорилтыг амжилттай хэрэгжүүлснээр хүчирхэг эдийн засагтай, хөгжингүй улс болж чадна гэж үзэж буйгаа илэрхийлсэн юм.

Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан эхний зөвлөгөөн хаврын тариалалтын өмнө болж, "Атрын IV аян-Эх орны эрүүл хүнс" уриатай тулгамдсан асуудлаа ярилцаж, бодлого, чиглэлээ тодорхойлон, иргэдийг эрүүл хүнсээр хангах, үнийн өсөлтийг сааруулах, хүнсний аюулгүй байдлаа бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа. Гурван өдөр үргэлжилсэн "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Газар тариалан" үндэсний чуулганаар "Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн", "Агрономчдын улсын хоёрдугаар зөвлөгөөн", "Төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалан, зоорийн аж ахуй эрхлэгчдийн улсын зөвлөгөөн", "Жимс, жимсгэнэний тариалан эрхлэгчдийн улсын зөвлөгөөн" зэрэг салбар зөвлөгөөн зохион байгуулагдав.



"Хүнсний хангамж, аюулгүй байдал- Хүнс үйлдвэрлэл" үндэсний зөвлөгөөн

2022.06.07

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хүнс үйлдвэрлэгчид түүчээлэн дэмжиж, "Хүнсний хангамж, аюулгүй байдал-хүнс үйлдвэрлэл" зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулсан. Ерөнхийлөгч Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийн гол асуудал нь хүн ардаа эрүүл, шим тэжээлтэй, стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангах явдал гэдгийг онцлоод "Хоолыг эм шиг хэрэглэхгүй бол хожим нь эмийг хоол шиг хэрэглэдэг болно" гэсэн үгийг эш татав. Түүнчлэн "Өсөн үржиж, урган төлждөг хөдөө аж ахуйн баялгаараа дэлхийн том зах зээл рүү монголчууд гарч, органик хүнс экспортлогч улс болох ёстой. Бид зөвхөн уул уурхайн салбарыг шүтэн амьдардаг биш, хөдөө аж ахуй, газар тариалангаа хөгжүүлж, энэ салбараас асар их ашиг олох боломж байгаа. Үүнийг та бүхэн мэдэж байгаа. Одоо харин ажил хэрэг болгох нь чухал байна. Энэ алтан боломжийг бүрэн дүүрэн ашиглах ёстой" хэмээв.



"Хүнсний хангамж, аюулгүй байдал-хүнс үйлдвэрлэл" зөвлөгөөнд хүнс үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, эрдэмтэн судлаачид оролцсон. Улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хүн бүр "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг эх оронч хэрэглэгч байхыг Төрийн тэргүүн зөвлөгөөнд оролцогчид болон ард түмэндээ уриалж байлаа. Зөвлөгөөний үеэр Д.Сүхбаатарын талбайд "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Хүнс үйлдвэрлэл" үзэсгэлэн худалдааг гурван өдрийн турш зохион байгуулж, 57 аж ахуйн нэгж, гурван холбоо оролцож, эх орондоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнээ танилцуулж, борлуулсан юм.

“Хүнсний хангамж аюулгүй байдал-Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци” үндэсний зөвлөгөөн

2022.06.27



Төрийн тэргүүн нээлтийн үгэндээ “Монгол төрийн бодлогыг шинжлэх ухаанчаар харах шаардлагатай. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад эрдэмтдийн оролцоо чухал. Манай улс 40 гаруй сортыг эх орондоо нутагшуулжээ. Одоо бид ирэх таван жилд 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах бүх талын боломж бүрдлээ” хэмээн онцлов. Зөвлөгөөнд шинжлэх ухаан, боловсролын байгууллага, хувийн хэвшил, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн үйлдвэрлэгч зэрэг салбар салбарын 800 орчим зочид, төлөөлөгч оролцсон

бөгөөд салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ач холбогдол бүхий судалгааны үр дүн, эрдэмтэн судлаачдыг дэмжиж, сайдын нэрэмжит шагналаар шагнав. Түүнчлэн хүнс, хөдөө аж ахуйн салбарын инновацийн төслийн үр дүнд гарсан биологийн идэвхт бүтээгдэхүүн, тэжээлийн ургамал, шинэ сорт, үр тариа, ургамал хамгаалал, пестицид, бордоо, эрчимжүүлсэн мал аж ахуй, малын үүлдэр, угсаа, бэлчээр, тэжээл, мал амьтны гаралтай инноваци шингэсэн 100 гаруй нэр төрлийн төрөлжсөн бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулагдав.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацийн талаарх ойлголт, мэдлэг, соёлыг түгээх, дамжуулах, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлж, инновацийн олон талт түншлэлийг өргөжүүлэх, чадавхыг бүрдүүлэх замаар мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх, “Халамжаас хөдөлмөрт”, “Олборлолтоос боловсруулалтад”, “Импортоос экспортод” шилжих зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх зорилгоор Ерөнхийлөгчийн ивээл дор “Хүнсний хангамж, аюулгүй байдал-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци” үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулав.



“Хүнсний хангамж, аюулгүй байдал- Мал аж ахуй” үндэсний чуулган

2022.10.25

Чуулганд салбарын төрийн болон хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны болон олон улсын байгууллага, мал зүйч, малын эмч, фермер, малчид тэргүүтэй нийслэл, 21 аймаг, 330 сумын 800 гаруй төлөөлөгч оролцлоо.



Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганыг нээж “Монголчууд бид байгалиас заяасан баялаг, нөөц боломждоо тулгуурлан хөгжих учиртай. Буянт мал сүрэг бол манай ард түмний үнэт эрдэнэ, манай улсын үндэсний баялаг юм” хэмээн тодотгоод мах, махан бүтээгдэхүүний экспортоор дэлхийн зах зээл рүү гарч, ашиг, орлого олохын зэрэгцээ бүс нутгийн болон дэлхийн хүн амын хүнсний хангамжид ирэх таван жилд мал сүргээ эрүүлжүүлж, ашиг шим, чанарт нь анхаарч, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, өргөн хэрэглээний 19 хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангахад малчдаа манлайлан оролцохыг уриалав.



Чуулганаар “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчин”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал-Мал аж ахуй”, “Малчдын нийгмийн хамгаалал”, “Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх цогц арга хэмжээ”, “Мал аж ахуйн ирээдүй”, “Мал аж ахуйн салбарын хүний нөөц”, “Хувийн мал эмнэлгийн өнөөгийн байдал”, “Арьс, шир, мах, сүү бэлтгэх, боловсруулах, нийлүүлэхэд тулгамдаж буй асуудал” зэрэг сэдвээр илтгэл сонсон, хэлэлцэж, хуванцар савыг хэрэглээнээсээ халах уриалга гаргасан юм.

“Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний зөвлөгөөнийг эхлүүлснээс хойш малчид, тариаланчид, хүнс үйлдвэрлэгчид болон салбарын эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан дөрвөн удаагийн үндэсний зөвлөгөөн, чуулган зохион байгууллаа. Эх орны өнцөг булан бүрээс салбарын төлөөллийг уриан дороо уулзуулж, зөвлөлдөн санал, хүсэлт, тулгамдсан асуудлуудыг нь сонсож, гарц, шийдлийг эрэлхийлсэн Төрийнхөө тэргүүнд зөвлөгөөний зочид, төлөөлөгчид талархал илэрхийлж байлаа”


Бэлтгэсэн: С.Мөнхжаргал

Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түнш бүлгийн хуралдаан боллоо

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний гол цөмийг танилцуулах, хамтын ажиллагааг тодорхойлох зорилго бүхий Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түнш бүлгийн хуралдаан 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр боллоо.



Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түнш бүлгийн хуралдаанд МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, АНУ Болон ОХУ-ын Элчин сайдын яам, Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Азийн хөгжлийн банк, Дэлхийн Банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын төлөөллүүд оролцож санал солилцсон юм.”



Хөгжлийн түнш байгууллагуудын төлөөллүүд хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого, уялдаа холбооны талаар хэлэлцүүлэг өрнүүлж, хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг экспортод гаргахдаа системийг сайжруулж, хөгжүүлэх, түүхий эдээ боловсруулах, нөөц боллоцоогоо ашиглах гэх мэт цаашдын хамтын ажиллагаа, хийж хэрэгжүүлж буй ажлуудаа танилцууллаа.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОТ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ О.Буяннэмэх:

Монгол Улсын Ерөнхийлөгч "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг санаачилж, УИХ-аас Төрийн тэргүүний санаачилгыг дэмжиж, 5 жилийн хугацаанд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилт бүхий 1,7 их наяд төгрөгийн төсөвтэй 36-р тогтоолыг баталсан. Тус тогтоол нь хэрэгжүүлэх арга зам, төлөвлөгөө, төсөвтэй батлагдсан нь онцлог юм. Тогтоолд хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах олон зорилтыг дэвшүүлсэн. Эдгээрээс онцолбол Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол малыг бүрэн эрүүлжүүлэх, цаашилбал малын гоц халдварт өвчингүй эрүүл бүс болох тал дээр анхаарлаа хандуулсан. Иймээс ойрын таван жилийн хугацаанд малыг бүрэн эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, биобэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар УИХ-аас баталсан тогтоолд оруулсан билээ. Энэ бол туйлын чухал. Үүнийг эрчимжүүлэхээр ХХААХҮ-ийн сайдын тушаалаар малыг эрүүлжүүлэх, биобэлдмэлийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, вакцины хамааралгүй улс болох чиглэлд ажиллах ажлын хэсгийг байгуулсан. Бид дотооддоо шүлхий өвчнийг хяналтандаа авах тал дээр онцгой анхаарч, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Малыг эрүүлжүүлэхэд Төр, засгийн бодлого, оролцооноос гадна малчдын оролцоо, үүрэг, хариуцлага маш чухал. Тийм ч учраас Ерөнхийлөгчийн ивээл дор "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Мал аж ахуй" үндэсний чуулганыг зохион байгууллаа. Нэн тэргүүнд малчдын амьжиргаа, нийгмийн баталгааг сайжруулахад онцгой анхаарч, эрүүл мэнд, нийгмийн даатгалд бүрэн хамруулах, тэтгэвэр, тэтгэмж, даатгалын үйлчилгээг боловсронгуй болгох, малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чанартай хүргэхэд анхаарах хэрэгтэйг илэрхийлсэн билээ. Дараагийн чухал асуудал нь малчид тооноос илүү чанарт шилжиж, ашиг шимийг нь нэмэгдүүлж, үүлдэр угсааг сайжруулан бэлчээрийнхээ даацыг бууруулж, зохистой ашиглахыг зөвлөж, Төр, засгаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах ёстойг онцолсон. Төрийн тэргүүний хөндсөн хамгийн гол асуудал бол ирэх таван жилийн хугацаанд Монгол Улсыг малын халдварт болон гоц халдварт өвчингүй бүс болгох. Үүнд хамгийн чухал үүрэгтэй манлайлан оролцох хүмүүс бол малчин түмэн. Ирэх 2023 оны төсөвт мал аж ахуйн салбарт, тэр дундаа малыг эрүүлжүүлэхэд зориулж 41,7 тэрбум төгрөгийг баталсан.

Монгол малыг эрүүлжүүлэхэд 180 мянган малчин түмний маань оролцоо маш чухал. Мал эрүүл байвал хүнс эрүүл, хүнс эрүүл байвал хүн эрүүл байна. Бид нэгдэж, хоршиж малаа эрүүлжүүлж, хүн ардынхаа эрүүл мэндэд үнэтэй хувь нэмэр оруулж, хөдөө аж ахуйн баялаг, түүн дотроо мах, махан бүтээгдэхүүний экспортоор дэлхийн зах зээл рүү гарч, ашиг орлого олохын зэрэгцээ бүс нутгийн болон дэлхийн хүн амын хүнсний хангамжид Монгол Улс хувь нэмрээ оруулах учиртай. Тиймээс бүгдээрээ "Хүнсний хувьсгал"-д нэгдэхийг уриалж байна.





ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨХ Ч.Даваабаяр:

Дэлхий нийтэд хүнсний хангамж, аюулгүй байдал нь нэн тулгамдсан асуудал болж буйг НҮБ-аас удаа дараа мэдээлсэн. Олон улсын түвшинд аюултай хэмжээнд хүрсэн тус асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч онцгойлон анхаарч, эх орондоо "Хүнсний хувьсгал" хийх санаачилга гаргаж, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36-р тогтоолыг УИХ-аас баталсан билээ.

Төрийн тэргүүний санаачилсан "Хүнсний хувьсгал" дор түүхэндээ анх удаа төрийн 29 байгууллага нэгдэж, 4 байнгын хороо хяналт тавьж, олон улсын байгууллагууд дэмжиж ажиллахаа илэрхийллээ. Үндэсний хөдөлгөөний хүрээнд улсын хэмжээний томоохон дөрвөн зөвлөгөөнийг зохион байгуулж, мөн 21 аймаг, нийслэлд "Хүнсний хувьсгал" зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулав. Түүнчлэн Монгол Улсаа хилийн чанадад төлөөлөн суугаа дипломат газруудад хамтран ажиллах тухай албан саналыг хүргээд байна. Ийнхүү "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн 21 аймаг, нийслэлд нээлтээ хийж дууссанаар, 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашлаад экспортлогч орон болохын төлөө зорьж буй "Хүнсний хувьсгал"-ын эхлэл тавигдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс орон даяар эрчимжлээ.

"Хүнсний хувьсгал"-ыг орон нутгийн удирдлагууд, хүнс үйлдвэрлэгчид, олон улсын байгууллагууд, баялаг бүтээгчид, малчид, тариаланчид дэмжиж, хамтран ажиллахаа бидэнд илэрхийлсээр байна. Мэдээж бид энэхүү үндэсний хэмжээний хөдөлгөөнийг өрнүүлж, хэрэгжүүлэх явцад та бүхнийхээ зөв зүйтэй, оновчтой санал, хүсэлтийг тусгаж, сайжруулж, илүү чанаржуулна. Энэ хувьсгал нь цаашид аж үйлдвэрийн хувьсгал болж өргөжих учиртай. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжинэ. "Хүнсний хувьсгал" дор нэгдэж, дэмжиж, хамтран ажиллаж буй баялаг бүтээгчид Та бүхэндээ гүн талархал илэрхийлье. Хүнс бол бидний эрүүл мэнд, амь нас, аж амьдрал, ирээдүй хойч үе, цаашлаад эх орны эдийн засагт ч нөлөөлөх амин хүчин зүйл. Тиймээс хүн нэг бүрийн оролцоо, хүчин чармайлт чухал билээ. Бүгдээрээ нэгдэж, хамтдаа "Хүнсний хувьсгал" хийхийг уриалж байна.


Баялаг бүтээж эх орондоо сайхан амьдарцгаая.



Өрх бүлээрээ хүнс үйлдвэрлэгч, улс орноороо хүнс экспортлогч болох зорилгод төр, засаг, ард түмнээрээ нэгдэж, нэгэн сэтгэлээр хамтран зүтгэцгээе.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, ахмад тариаланч, Монгол Улсын Гавьяат агрономич Д.Батаагийн хамт.

"Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах тухай" Засгийн газрын тогтоол батлагдлаа



Хүн төрөлхтний өмнө уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, геополитик, тээвэр ложистикийн асуудлаас улбаалсан хүнсний хомсдол үүсэж болзошгүй байгаа энэ хүнд цаг үед Монгол Улсын Засгийн газраас удирдлага зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, улмаар экспортод гаргах боломжийг бий болгоход онцгой анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд малын эрүүл мэндийг хамгаалж эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, экспортыг тогтвортой явуулах зорилгоор хилийн боомтуудыг түшиглэн "Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс" байгуулах зорилт дэвшүүлж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан батлууллаа. Энэхүү бүсийг олон улсын шаардлагад нийцүүлэх зорилгоор мал эмнэлгийн хяналтын цэг, лаборатори байгуулах, эм урвалж, тоног төхөөрөмж, бэлчээрийн уст цэг, хамгаалалтын байгууламж барих замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ногоон мал аж ахуй эрхэлж, малын бэлчээр, тэжээл, усан хангамжийг бүрдүүлэх, хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

БАРУУН БҮС: Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн бүх нутаг дэвсгэрт,



ТӨВИЙН БҮС: Хөвсгөл аймгийн Ханх, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Эрдэнэбулган, Булган аймгийн Тэшиг сумын бүх нутаг дэвсгэрт,

ЗҮҮН БҮС: Хэнтий аймгийн Дадал суманд 50.0 мянган га хүртэл талбай, Дорнод аймгийн Халхгол сумын Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн тусгай хэрэгцээний 120.0 мянган га хүртэл талбайд тус, тус эрүүл бүсийг байгуулах юм.

Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүсийг байгуулснаар мал сүргийг мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд тогтмол бүрэн хамруулж, үржлийн бус эр сувай малыг эрчимтэй шахаж бордон эдийн засгийн эргэлтийг сайжруулж, өвс, тэжээлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг баримтлан бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шинэ технологи, инновацыг нэвтрүүлнэ.

ТУСГААРЛАХ БҮС БАЙГУУЛАГДСАНЫ ҮР АШИГ, АЧ ХОЛБОГДОЛ:

- Малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчингүй эрүүл бүс бий болно.
- Мах, махан бүтээгдэхүүний үнэ цэн өсөж, үйлдвэрлэл тогтвортой явагдана.
- Олон улсын эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүний экспортыг тогтвортой явуулах боломжийг бүрдүүлнэ.
- Малын гаралтай бүтээгдэхүүнийг тогтмол зах зээлд нийлүүлнэ.
- Үржлийн бус эр сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар малын чанар, үүлдэр угсааг сайжруулна.
- Мал сүргийн тооны хэт өсөлтийг бууруулж, бэлчээрийн даац, ачааллыг багасгана.
- Бүс нутагт ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Малчдын орлогыг нэмэгдүүлнэ.



ОРОН НУТГИЙН БАЯЛАГ БҮТЭЭГЧИД "ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ"-Д НЭГДЛЭЭ.

"Хүнсний хангамж-Аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн нийслэл болон 21 аймагт нээлтээ хийж дууссанаар, 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашлаад экспортлогч орон болохын төлөө зорьж буй "Хүнсний хувьсгал"-д эх орны өнцөг булан бүрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй баялаг бүтээгчид нэгдэж эхэллээ.



Хүнсний салбарын "шилдэг 100" шалгаруулах ажлын хэсгийн анхдугаар хуралдаан боллоо.



Баруун бүсийн бүтээн байгуулалт "Ховд эко цемент" үйлдвэрт ажиллалаа.



Малын удмын сангийн үндэсний төв" цогцолборт ажиллалаа. /Дархан-Уул аймаг/



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
 ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

Хүнс эрүүд бол хүнс

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Ухнаагийн ХҮРЭЛСҮХ
 “ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ”
 ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД
**ХҮНСНИЙ САЛБАРЫН
 ҮЙЛДВЭРҮҮДЭД АЖИЛЛАЛАА**

Ирэх таван жилд 19 гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээ хангаж, улмаар экспортлогч орон болох зорилтыг хэрэгжүүлэхэд үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, баялаг бүтээгчид чухал хувь нэмэр оруулна гэж үздэгээ Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх онцоллоо.

Дархан-Уул аймгийн мах боловсруулах үйлдвэр “Дархан-Эрдэнэ мах комбинат” ХХК-д ажиллалаа. 2022.09.28



Үндэсний үйлдвэрлэгч “Үлэмж Органик” компанид ажиллалаа. 2022.10.18



Төв аймаг, Цээл сумын тариалангийн талбай. 2022.09.28

Эх орны хөрсөнд ургасан эрүүл улаанбуудайг боловсруулан, экологийн цэвэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж хүн амыг эрүүл хүнсээр ханган ажиллаж буй үндэсний үйлдвэрлэгч “Өөг” гурилын үйлдвэрт ажиллалаа. 2022.09.28



Сэлэнгэ аймгийн “Өгөөж Мандал Уул” ХХК-ийн ургац хураалтын явцтай танилцаж, тариалангийн талбайн ойн зурвас, мод үржүүлгийн төвд ажиллалаа. 2022.09.28



Дотоодынхоо хүнсний хэрэгцээг хангах их үйлт зүтгэн ажиллаж буй үндэсний томоохон баялаг бүтээгч “Гацуурт Хүнс” компанийн үйл ажиллагаатай танилцлаа. 2022.10.18



Дархан-Уул аймгийн “Шинэ Орчин Трейд” ХХК-ийн ногоо хураалтын явцтай танилцлаа. 2022.09.28



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Баялаг Фийд” тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. 2022.10.18



Бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг эх орныхоо хэрэглэгчдэд төдийгүй Орос, Хятад, Араб болон Иран гэх мэт гадаад орнууд руу нийлүүлдэг “Цалуут Имлекс” компанийн үйлдвэрт ажиллалаа. 2022.10.17



“М-Си-Эс Кока Кола” ХХК нь 21 брэндийн 150 төрлийн ундаа, ус, жүүс, цай үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг бөгөөд 950 хүнийг ажлын байраар хангаж байна. 2022.10.17





Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

Хөрс эрүүл бол хүнс эрүүл – Хүнс эрүүл бол хүн эрүүл

Илүү сайн
үйлдвэрлэл



Илүү сайн
шим тэжээл



Илүү сайхан
хүрээлэн буй
орчин



Илүү сайхан
амьдрал



Төрийн ордон, Улаанбаатар хот 14201,
Монгол улс

Ерөнхийлөгчийн Тамгын Газрын
Хүнсний төсөл, хөтөлбөрийн алба

